ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## (2016 оны эхний хагас жилийн дүнгээр)

**Улаанбаатар хот**
**2016-06-28**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ –**
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

(2016 оны эхний хагас жилийн дүнгээр)

2016.06.28 Улаанбаатар хот

| **Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | | **Хариуцах нэгжийн нэр** | **Биелэлт, Хүрсэн түвшин (Шалгуур үзүүлэлтээр), Хэрэгжилтийн хувь** |
|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээний шалгуур үзүүлэлт** (тоо, чанар хугацаа)**-ийн хүрэх түвшин** | **Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин** | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Нэг. “Худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх, худалдан авах ажиллагааны талаарх төрийн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг хангах”** гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: | | | | |
| **ХӨТӨЛБӨР I**<br>**“Худалдан авах ажиллагааны тогтолцоо, удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн хууль, эрх зүйн орчин, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 1.1.1.**<br>Цахим худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, жишиг баримт бичгийг шинэчлэх төсөл боловсруулж, саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх | - Цахим худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг сайжруулах,<br>- Жилдээ. | Цахим худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, жишиг баримт бичиг шинэчлэгдэж, үйл ажиллагаанд мөрдсөн байна. | МТИХ | Монгол Улсын Засгийн газрын Худалдан авах ажиллагааны тогтолцоонд Ерөнхий гэрээг нэвтрүүлэх зорилгоор 2016 оны 01 сарын 25-29-ны өдрүүдэд ЕСБХБ-ны төслийн зөвлөхүүдтэй хийсэн ажлын хэсгийн уулзалтад МТИХ-ийн дарга Д.Лхамсүрэн, Ахлах мэргэжилтэн Н.Цэрэнсамбуу нар оролцов. Уг уулзалтаар Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааны тайлан, тус банкны зүгээс Монгол Улсад санал болгож буй Ерөнхий гэрээний журмын төслүүдтэй танилцаж санал солилцож байгууллагын байр суурь, саналыг илэрхийлэв. Түүнчлэн, Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг танилцуулж харилцан саналуудыг хэлэлцсэн.<br>Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төлөөлөгчидтэй 2016 оны 04 сарын 25-28-ны өдрүүдэд Ерөнхий гэрээний журмыг боловсруулах төслийн багийн уулзалтад МТИХ-ийн Ахлах мэргэжилтэн Н.Цэрэнсамбуу оролцож, байгууллагын саналыг тусгуулав. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 1.2.2.**<br>Худалдан авах ажиллагаанд хэрэглэгдэж буй хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт- | - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад шаардлагатай хууль | Шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хууль санаачлагчид, холбогдох дээд | ХХХэлтэс | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, үзэл баримтлал, танилцуулгын хамт 2016.03.04-ний өдөр байгууллагын удирдлагын түвшинд танилцуулагдсан. Төсөлд худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын удирдлагын тогтолцоог босоо болгох, гадаадын этгээд оролцох барааны тендер шалгаруулалтын босго үнийг 1 тэрбум |

| | | | | |
|---|---|---|---|---|
| шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах | тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах,<br>- Байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтээс санал авах,<br>- Хууль санаачлагчид, дээд шатны байгууллагад хүргүүлэх,<br>- Тухай бүр. | шатны байгууллагад хүргэсэн байх. | | 1 төгрөг болгох зэрэг асуудлууд багтсан болно.<br>Мөн Худалдан авах ажиллагааны газрын хэлтсүүдийн 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэлтсийн дарга, албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн явц, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилтийн байдалд дотоод хяналт, шалгалт хийх ажлын удирдамжийг боловсруулж, 2016.06.14-ний өдрийн А/75 тоот тушаалаар батлуулсан. 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор илтгэх хуудсыг бэлэн болгон газрын удирдлагад танилцуулахаар ажиллаж байна. Энэхүү хяналт шалгалтын ажил хийгдсэнээр дотоод хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэхээр төлөвлөж байна.<br>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд байгууллагаас санал өгсөн ба шинэчилсэн найруулгын төсөл Улсын Их Хурлаар батлагдаж, 2016.07.01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэх гэж байна. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд худалдан авах ажиллагаатай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, маргааны харъяаллын талаар санал тусгуулах арга хэмжээ авсан. (ХШ-90%) |
| **ХӨТӨЛБӨР II**<br>**“Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг дээшлүүлж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 2.1.3.** Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чадавхийг сайжруулах хөтөлбөр боловсруулах | - Хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулах,<br>- Хөтөлбөр боловсруулж батлуулах,<br>- Шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох,<br>- II-IY улиралд. | Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чадавх сайжирсан байна. | ТСХ | Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чадавхийг сайжруулах хөтөлбөрийг боловсруулах хүрээнд Удирдлагын академийн багш нартай хамтран ажиллаж байна. 2016 оны 04 сарын 28-ны өдөр Удирдлагын академийн багш, доктор Н.Бямбасүрэнг урьж, Төлөвлөлт, судалгааны хэлтсийн албан хаагчдын дунд уулзалт - ярилцлага зохион байгуулан холбогдох зөвлөгөө авч ажиллаж байна. (ХШ-50%) |
| **Арга хэмжээ 2.2.4.** Хөдөлмөрийн дотоод журам болон бусад | - Албан хаагчдаас санал авах,<br>- Хуулийн үндэслэлтэй | Байгууллагын дотоод журам боловсронгуй | ХХХэлтэс, ЗУХ | Хөдөлмөрийн дотоод журамд оруулах өөрчлөлтийн төслийг Хууль, хяналтын хэлтсээс нэгтгэн боловсруулж, газрын даргад танилцуулсан, батлагдаагүй хүлээгдэж байгаа. Хэлтсүүдээс уг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| журамд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулах | боловсруулах,<br>- Тодорхой асуудлыг шийдвэрлэсэн байх,<br>- Тухай бүр. | болно. Сахилга хариуцлагын хэм хэмжээ тодорхой болсон байна.<br>Мөрдөж ажилласан байна. | | журмын шинэчилсэн найруулга, өөрчлөлттэй холбоотой саналыг авч тусгахад ЗУХ-ээс холбогдох саналыг боловсруулан тусгуулахаар XXXэлтэст өгсөн.<br>Одоогоор албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг 2015 оны 03 сарын 26-ны өдрийн № 22 дугаар тушаалаар өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам” болон 2015 онд түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн үйлчлэлийг мөрдөж байна.<br>Ерөнхий гэрээний журамтай холбоотой 2016.04.25-аас 28-ны хооронд зохион байгуулагдсан СЯ-ны уулзалт, Европийн сэргээн босголт, хөгжлийн банкны зөвлөхийн сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, ХААГ-т хийсэн уулзалт, журмын төсөл боловсруулах ажлын хэсэгт тус байгууллагын төлөөлөл оролцсон. Энэхүү асуудлын хүрээнд, Ерөнхий гэрээний журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн талаар 2016.02.01-ний өдрийн 1/75 дугаар албан бичгээр, Ерөнхий гэрээ байгуулан хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг эхлүүлэх талаар чиглэл хүсэх тухай хүсэлтийг 2016.02.04-ний өдрийн 1/85 дугаар албан бичгээр Сангийн яам, Шадар сайдын Ажлын албанд тус тус хүргүүлсэн. Уг ажлын хэсгээс Ерөнхий гэрээний журмын төсөлд оруулах саналыг эцэслэн боловсруулж, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зөвлөхөд илгээсэн. Мөн Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бичгийн цаас, шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна. Шатахуун, бичгийн цаас нийлүүлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй Үнэлгээний хорооноос уулзалт зохион байгуулсан. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 2.3.5.** Байгууллагын 2016 оны төсвийн бүрдүүлэлт, хуваарилалтыг хэрэгжүүлэн, хяналт тавих, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах, 2017 оны төсвийн төлөвлөлт хийх, | - Санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд аудит, дотоод аудит хийгдсэн байх,<br>- Хяналт тавьж ажилласан байх,<br>- Мэдээллийн ил тод байдлыг хангаж, “Шилэн дансны хууль”-ийг хэрэгжүүлж ажилласан байх,<br>- Төсвийн төлөвлөлтийг бодитой төлөвлөсөн | Төсвийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж сайжирсан байна.<br>Аудитын зөрчил, доголдол гараагүй байна.<br>2017 оны төсвийн төлөвлөлт хийгдсэн байна. | ЗУХ, XXXэлтэс | <u>2017 оны төсвийн төлөвлөлт, 2016 оны төсвийн хуваарилалт, зарцуулалт:</u><br>2017 оны төсвийн хязгаарын төслийн саналыг бэлтгэж байна. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд ХААГ-ын төсөв 1,1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төсвийн Ерөнхийлөн захирагч Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 01-р сарын 12-ны өдрийн 4-1/182 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн хуваарийн дагуу байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийг авч, өдөр тутмын төлбөр, тооцоог гүйцэтгэн, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж байна. Батлагдсан хуваарийн дагуу 1-5 сард 377,2 сая төгрөгийн төсвийн орлогын, 373,0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус хийв. Хэвлэл мэдээллийн байгууллагуудад үүссэн өглөгийг барагдуулж, ажиллагсдын цалинг цаг хугацаанд нь сард 2 удаа хуваан бодож олгосон. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байх,<br>- Жилдээ. | | | 2015 оны жилийн эцэст Засгийн газрын автобаазад 6,8 сая төгрөгийн өглөгтэй байсан бол 2016 оны эхний хагас жилийн хугацаанд 2,2 сая төгрөг төлөгдсөнөөр өглөг 4,6 сая төгрөг болж буурсан.<br><br><u>Хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаар:</u><br><br>2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 55 үндсэн ажилтан, 9 гэрээт ажилчин, албан хаагчийн эд хөрөнгө ашиглалтын бүртгэлийг хөтлөв.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 439 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны 04 сарын 06 өдрийн 126 дугаар тушаал, Худалдан авах ажиллагааны газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/63 дугаар тушаалуудыг үндэслэн эд хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулав.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллоготой холбогдуулан дотоод тооллогын комиссыг байгуулан, 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон тооллогыг явуулж, дүнг 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын удирдлагад танилцуулав. Тооллогын дүнг эд хариуцагчийн карт болон бэлэн байгаа үлдэгдэл, Нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг тооцож гаргав. Уг тооллогоор бүртгэлээр байвал зохих 2002 ширхэг 517,8 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө бүрэн тоологдсон.<br><br><u>Аудитын зөрчил, доголдлын талаар:</u><br><br>ХААГ-ын 2015 оны санхүүгийн тайланд 2015 оны 9-р сар, 2016 оны 02 сард аудитын шалгалт хийгдсэн. ҮАГ-ын 2016.02.19-ний өдрийн 3/185 тоот аудитын дүгнэлтээр “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.<br><br>ҮАГ-аас 2015 оны 4-р улирлын санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад санхүүгийн баримтад явцын шалгалт хийгдэж, аудитын нийт 4 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэхэд анхааран ажилласны дүнд хэрэгжилтийг 92.5 хувиар ханган ажиллав. Зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой дараах үр дүнг дурдвал:<br><br>- Төсвийн тухай хуулийн холбогдох заалт, улсад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахад анхаарч, эхний хагас жилийн төлөвлөгөөгөөр 15,0 сая төгрөгийн орлого |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | төвлөрүүлэхээс 26,7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг давуулан биелүүлсэн.<br>- Байгууллагын төсвийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулан ажиллаж байна.<br>- Санхүүгийн тайлан үнэн зөв, баримт материал, бодит тоон мэдээнд үндэслэсэн байх шаардлагыг баримтлан ажиллаж байна.<br>- “Цахим худалдан авах ажиллагааны II үе шат” төслийн гэрээний биелэлтийг дүгнэж, холбогдох асуудлыг шийдвэрлэн, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хүлээгдэж байгаа. “Цахим худалдан авах ажиллагааны II үе шат” төслийн ажил дуусаагүй байгаагаас үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх боломжгүй байна.<br><br>Худалдан авах ажиллагааны газрын хэлтсүүдийн 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэлтсийн дарга, албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн явц, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилтийн байдалд дотоод хяналт, шалгалт хийхээр 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/75 дугаар тушаал гарч, удирдамж, төлөвлөгөө батлагдсан. Энэхүү хяналт, шалгалтын хүрээнд байгууллагын төсөв, санхүү, хөрөнгийн үр өгөөж, ашиглалтад хяналт хийж, хэрэгжүүлэхээр тусгаад байна. Хяналт, шалгалтын ажил дуусаагүй байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 2.4.6.** Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах | - Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, бүртгэл хийх,<br>- Эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын асуудлыг Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлж, Даргын зөвлөлд танилцуулах,<br>- Хагас, бүтэн жилд. | Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сайжирсан байна. | ЗУХ, Өмч хамгаалах зөвлөл | 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 55 үндсэн ажилтан, 9 гэрээт ажилчин, албан хаагчийн эд хөрөнгө ашиглалтын бүртгэлийг хөтлөв.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 439 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны 04 сарын 06 өдрийн 126 дугаар тушаал, Худалдан авах ажиллагааны газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/63 дугаар тушаалуудыг үндэслэн эд хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулав.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллоготой холбогдуулан дотоод тооллогын комиссыг байгуулан, 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон тооллогыг явуулж, дүнг 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын удирдлагад танилцуулав. Тооллогын дүнг эд хариуцагчийн карт болон бэлэн байгаа үлдэгдэл, Нягтлан бодох |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг тооцож гаргав. Уг тооллогоор бүртгэлээр байвал зохих 2002 ширхэг 517,8 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө бүрэн тоологдсон. Үүнд: Авто машин, машин, тоног төхөөрөмж - 1264 ширхэг, 292,3 сая төгрөг, тавилга эд хогшил - 730 ширхэг, 192,9 сая төгрөг, программ хангамж - 8 ширхэг, 32,5 сая төгрөг.<br><br>Албан хаагчдын ашиглаж буй тавилга, тоног төхөөрөмжид байнга хяналт тавьж, дутсан болон эвдэрсэн хөрөнгүүдийг төлүүлэх, засуулах арга хэмжээг тухай бүр авч, байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаН ажиллаж байна. 2016 оны эхний хагас жилийн байдлаар элэгдлийн хугацаа дууссан тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг гаргаж актлуулах, дахин үнэлүүлэх арга хэмжээ авч байна. Төрийн өмчийн ашиглалт, хяналтын нэгдсэн системд үндсэн хөрөнгийн бүртгэлийг оруулж дууссан бөгөөд улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа "Төрийн өмчийн ашиглалт, хяналтын нэгдсэн тооллого"-д хамрагдаж байна. (Б-100%) |
| **Арга хэмжээ 2.5.7.** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх | - Хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх,<br>- Байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын талаар хуульд заасан мэдээллийг ил тод болгох,<br>- Жилдээ. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдана. Мэдээ, мэдээлэл ил тод, нээлттэй болно. | ЗУХ | "Шилэн дансны тухай хууль"-ийн дагуу байгууллагын төсөв, санхүү, түүний зарцуулалтын талаарх мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллан, холбогдох хууль, журамд заасан мэдээллийг байгууллагын цахим хуудас www.e-tender.mn болон Засгийн газрын www.shilendans.gov.mn мэдээллийн нэгдсэн системд олон нийтийн зүгээс татаж авах, хэвлэх боломжтойгоор байршуулан мэдээлж, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг нийтлэв. Мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол шинэчилж хэвшсэн.<br><br>Үндэсний аудитийн газраас Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2015 онд хийсэн аудитаар өгсөн зөвлөгөө, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, ХААГ-ын 2015 оны Б/25 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны газрын шилэн дансны мэдээлэл хөтлөх журам"-ыг мөрдөж байна. "Нэг цэгийн үйлчилгээ"-ний танхимд байрлуулсан "Шилэн дансны мэдээллийн самбар"-т төсөв, санхүүгийн мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүрд шинэчлэн ил тод мэдээлж, иргэд, олон нийтийн зүгээс мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжоор хангав. Шилэн дансны хэрэгжилтийн тайланг улирал бүр ШСАА, ҮАГ-т тус тус хүргүүлсэн. ҮАГ-аас 2016 оны 05 сард Шилэн дансны ээлжит шалгалт хийгдсэн бөгөөд өгсөн заавар, зөвлөгөөг хэрэгжүүлж байна. (Б-100%) |
| **Арга хэмжээ 2.6.8.** | - Бүх шатны шүүхийн байгууллагатай | Байгууллагын эрх ашиг | ХХХэлтэс | Худалдан авах ажиллагааны газраас 2016 он гарсаар зохион байгуулсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан маргаан, гомдлыг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх | хамтран ажиллах,<br>- Шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд гарсан гомдол, нэхэмжлэлийн нэгдсэн санг тогтмол хөтөлж, тухай бүр шинэчлэх,<br>- Худалдан авах ажиллагаатай холбоотой маргаан, гомдол, нэхэмжлэлд анализ дүгнэлт хийх, анхаарах асуудлын талаар холбогдох хэлтэс, албан хаагчид тухай бүр танилцуулах,<br>- Тухай бүр. | хамгаалагдсан байна.<br>Гомдол мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Үндэслэлтэй гомдлын гаралт багассан байна. | | дүнтэй холбогдуулан захиргааны хэргийн шүүхэд 8,359.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнд 4 нэхэмжлэл гарсан бөгөөд, өмнөх онд нэхэмжлэл гарган он дамжин хянагдаж буй 15,495.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 ("Таван шүтээн трейд" ХХК, "Ви Эйч энд Би" ХХК, "Арт констракшн" ХХК) нэхэмжлэлд хариуцагч болон гуравдагч этгээдээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаад тус байгууллагаас оролцож байна.<br><br>Тайлангийн хугацаанд нийт 10 удаа шүүх хуралдаанд оролцсон ба нэхэмжлэлд хариу тайлбар, итгэмжлэл бэлтгэх, тендерийн баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангуулан тухай бүр хуулийн хугацаанд нь шүүхэд хүргүүлж ажилласан. Үүний дүнд, 2016 онд нэхэмжлэл гарган шүүхээр хянагдаж буй захиргааны хэргүүд нь эцэслэн шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бөгөөд өмнөх онд нэхэмжлэл гарган шүүхээр хянагдсан 14,4 тэрбум төгрөгийн "Ви Эйч энд Би" ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэгт нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, гэрээ байгуулахыг даалгаж шийдвэрлэсэн. Мөн 295,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нэхэмжлэгч "Таван шүтээн трейд" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг шүүхээс бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 2.7.9.**<br>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Спорт хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн албан хаагчдыг эрүүлжүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | - Шийдвэрлэвэл зохих асуудлыг тодорхойлох арга хэмжээ авах,<br>- Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байх,<br>- Жилдээ. | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн байна. | ЗУХ | Албан хаагчдын цалин хөлсийг хуулийн хүрээнд нэмэгдүүлэх боломж нөхцлийн талаар тооцоо судалгаа хийж, 1 албан хаагчид ажил үүрэг хавсран гүйцэтгэсний 40 хувийн нэмэгдэл олгосон.<br><br>Гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 4 албан хаагч тус бүрд 100.0 мянган төгрөгийн тэтгэмж тусламж, 3 албан хаагчид тус бүрд нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг мөнгөн хэлбэрээр тус тус олгосон. Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа 5 албан хаагч, хөлсөөр ажиллах байгаа 6 албан хаагчтай Хөдөлмөрийн гэрээний сунгалтыг тус тус хийв.<br><br>Нийт албан хаагчдын ажилласан жилийн судалгааг шинэчлэн гаргаж, төрийн албан хаагчдад зэрэг дэв олгох, зэрэг дэвийг ахиулах, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгуулах талаарх үндэслэлийг судлан, төрийн албанд ажилласан хугацаа нь шаардлага хангаж байгаа 2 албан хаагчид, хугацаанаас нь өмнө 2 албан хаагчид шинээр зэрэг дэв олгуулах хүсэлтийг Шадар сайдын Ажлын албанд 2016 оны 04 сарын 11-ний өдрийн 1/273 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.<br><br>Тус байгууллагын "Нэг цэгийн үйлчилгээний төв"-д байрлан ажиллаж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | байгаа Төрийн банкны салбар тооцооны төвтэй хамтран ажиллах гэрээг 2016 онд шинэчлэн батлахдаа тус байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд зохих банкны үйлчилгээний хөнгөлөлт, хялбаршуулалтын арга хэмжээг шийдвэрлэсэн ба энэ чиглэлээр байгууллагын зүгээс албан хаагчдад боломж олгож ажиллав. 2016 эхний хагас жилийн байдлаар, Төрийн банкны хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцны зээлд 2, орон сууцны энгийн зээлд 1, цалингийн зээлд 25 албан хаагч тус тус хамрагдсан байна. (Б-100%) |
| **Арга хэмжээ 2.8.10.** Байгууллагын албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, чадавхийг бэхжүүлэх | - Төлөвлөгөөт болон зорилтот сургалтад албан хаагчдыг хамруулах,<br>- Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, бусад байгууллагуудтай энэ чиглэлээр хамтран ажиллах,<br>- Жилдээ. | Боловсон хүчний мэдлэг, чадавхи дээшилсэн байна. | ЗУХ | Удирдлагын академийн Удирдахуйн Ухааны сургуулийн “Төрийн захиргааны менежмент” мэргэжлээр магистрын зэрэг олгох “Гараг”-ийн 2015-2016 оны сургалтад Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Д.Наранчимэгийг хамрагдахад боломж, нөхцлөөр хангасан бөгөөд амжилттай төгсөв. Мөн уг сургалтын 2016-2017 оны элсэлтийн сонгон шалгаруулалтыг байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулж, 1 албан хаагчийн материал, хүсэлтийг Удирдлагын академид хүргүүлэв.<br><br>Холбогдох төрийн болон олон улсын байгууллагаас зохион байгуулсан дараах сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор 19 албан хаагчийг хамруулж, тэдний мэдлэг, чадавхийг дээшлүүлсэн байна. Үүнд:<br>1. Сангийн яам, “Монгол улсад хүртээмжтэй өсөлтийн бодлогыг дэмжих” төслийн зөвлөгөөнд Газрын дарга Н.Отгонбаяр, ЗУХ-ийн дарга Ч.Жаргалан, МТИХ-ийн дарга Д.Лхамсүрэн, Ахлах мэргэжилтэн Н.Цэрэнсамбуу, мэргэжилтэн С.Чинбат, Д.Наранчимэг нар,<br>2. Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны сургалтад МТИХ-ийн Ахлах мэргэжилтэн Н.Цэрэнсамбуу, ТСХ-ийн Ахлах мэргэжилтэн Ц.Минжинхүү, ХААЗБХ-ийн Ахлах мэргэжилтэн У.Батзаяа, ХХХэлтсийн мэргэжилтэн Д.Номингэрэл, ХААЗБХ-ийн мэргэжилтэн Б.Халиун, Ф.Баатарсүх, Т.Бямбасүрэн, Б.Чинбаяр нар,<br>3. АТГ, ЭБАТ-ын сургалтад ЭБАТ Х.Энхчимэг,<br>4. ШӨХТГ, “Зах зээлийн өрсөлдөөнийг зохицуулах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” хэлэлцүүлэгт ХХХэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Буяннэмэх, ХААЗБХ-ийн Ахлах мэргэжилтэн У.Батзаяа, ХААЗБХ-ийн мэргэжилтэн Б.Эрдэнэбулган, Б.Сэргэлэн нар,<br>5. ОБЕГ, “Гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | түншлэлийг дэмжих форум"-д ЗУХ-ийн дарга Ч.Жаргалан нар,<br>6. Сангийн яам, "Дотоод аудитын туршилтын сургалт"-нд ня-бо Б.Мөнхзул, ХХХэлтсийн мэргэжилтэн Б.Марс-Од нар,<br>7. "Юстиция" ХХК хуулийн фирм, "Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 2 дугаар бүлэг: Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийн тайлан"–ийн хэлэлцүүлэгт ЭБАТ Х.Энхчимэг, ХААЗБХ-ийн мэргэжилтэн Б.Эрдэнэбулган, ХХХэлтсийн мэргэжилтэн Б.Марс-Од нар тус тус хамрагдав.<br><br>Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр нийт 5 албан хаагч Испани, БНСУ-д гадаадын сургалт, семинар, форумд оролцов.<br><br>Нийт албан хаагчдыг Хууль зүйн яамнаас зохион байгуулсан "Захиргааны ерөнхий хуулийн танилцуулга", Хаппивэритас ХХК-аас зохион байгуулсан эрүүл мэндээ хэрхэн хамгаалж, урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээнд хэрхэн хамрагдах талаарх эрүүл мэндийн зөвлөгөө, сургалтад тус тус хамруулав. (Б-100%) |
| **Арга хэмжээ 2.9.11.** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах | - Төлөвлөгөө боловсруулан төсөлд албан хаагчид, АТГ-аас санал авч, батлах, 1-2 сард,<br>- Хэрэгжилтийг хангах, жилдээ,<br>- АТГ, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, жилдээ,<br>- АТГ-т төлөвлөгөөний хувийг хүргүүлэх, 2 сард,<br>- Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлэн үнэлгээнд материал бүрдүүлж өгөх, 11 сард. | Авлига, ашиг сонирхлын зөрчил гараагүй байна. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа тогтмолжиж, Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд ахиц гарсан байна. | ЗУХ | Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг хэлтсүүд болон АТГ-аас санал авч, нийт 32 заалттайгаар боловсруулан батлуулав. Төлөвлөгөөний хувийг АТГ-т 2016-02-26-ны өдрийн 1/110 тоот албан бичгээр хууль, журамд заасан хугацаанд хүргүүлсэн. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд ABLE дотоод сүлжээнд байршуулан, нийт албан хаагчдад хүргэн мэдээлэв. Хэлтсүүд өөрийн хэлтэстэй шууд холбоотой зохион байгуулж хэрэгжүүлэх ажлаа хэлтсийн төлөвлөгөөндөө тусган ажиллах талаар 2016 оны 02 сарын 22-ны өдрийн удирдах ажилтны шуурхай хуралд мэдээлж, зааварчилга өгөв. Уг төлөвлөгөөн дэх ЗУХ-ийн шууд хариуцах ажлуудыг хэлтсийн сарын ажлын төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж байна.<br><br>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны үнэлгээнд дүгнэлт хийж, 2016 онд шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн ажлуудыг төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Үнэлгээний дүнгийн талаар АТГ-аас ирүүлсэн бичгийг нийт албан хаагчдад танилцуулахаар дотоод сүлжээнд байршуулан мэдээлэв. Соён гэгээрүүлэх ажлуудыг "Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгасан. Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг оны сүүлийн хагас жилд зохион байгуулна. (ХШ-90%) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Арга хэмжээ 2.10.12.** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг хангах | - Холбогдох мэдүүлэг, мэдэгдлийг албан хаагчдаас гаргуулан авч цахим системд бүртгэн, шаардлагатай бүртгэл, мэдээллийн сан үүсгэх, жилдээ,<br>- 2015 оны мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн тайлан, ЭБАТ-ын ажлын тайлан гаргаж, АТГ-т хүргүүлэх, 03 сарын 01-ний дотор. | Авлигын эсрэг, хууль тогтоомж, журам, заавар хэрэгжиж, тайлан, мэдээлэл холбогдох байгууллага, албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргэгдсэн байна. | ЗУХ | Мэдүүлэг гаргагч албан хаагчдын 2015 оны ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу хугацаанд нь зохион байгуулж, 2015 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн мэдээ, тайлан, Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны 2015 оны үйл ажиллагааны тайланг тус тус гаргаж, 2016 оны 02 сарын 29-ний өдрийн 1/121 тоот албан бичгээр АТГ-т хуулийн хугацаанд багтаан хүргүүлсэн. 2015 оны ХАСХОМ-ийг нийт 45 албан хаагч шинэчлэн гаргаж, мэдүүлэг гаргагч албан хаагчид 100 хувийн хамрагдалттайгаар хуулийн хугацаанд ХАСХОМ мэдүүлсэн.<br><br><u>2015 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын дүн:</u><br>✓ 45 албан хаагч ХАСХОМ шинэчлэн гаргасан.<br>✓ Нийт 8 албан хаагч давхардсан тоогоор 11 удаагийн их хэмжээний өөрчлөлтийг (2014+) мэдүүлсэн.<br>✓ ХАСУМ хянуулсан 27 нэр дэвшигчээс нийт 20 нэр дэвшигчийг албан тушаалд томилсон шийдвэр гарсан.<br>✓ Үнэлгээний хорооны гишүүдээс нийт 1101 ашиг сонирхлын мэдэгдэл гаргасан, тэдгээрийн 99,8 хувь нь “ашиг сонирхлын зөрчилгүй” гэдгээ уг мэдэгдлээр мэдэгдсэн.<br><br>Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох хууль, журамд заасан заавар, маягтын дагуу цаасан суурьтай бүртгэл хөтлөн хүлээж авсны зэрэгцээ 2015 оны мэдүүлэг бүрдүүлэлттэй холбоотой цаасан суурьт бүртгэлийг АТГ-ын Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем meduuleg.iaac.mn-ийн “ЭБАТ-ын бүртгэл” цэсний холбогдох бүртгэлд 2016 оны 1, 2 сард оруулж дуусган дүн, мэдээнд бүрэн хамруулав. Үүнд:<br>1. “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” (56 мэдэгдэл),<br>2. Мэдүүлэг гаргагч албан хаагчдын ХАСХОМ-ийг цаасаар хүлээн авч бүртгэл хөтөлсөн цаасан суурьт бүртгэл (66 мэдүүлэг),<br>3. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл (27 мэдүүлэг).<br><br><u>2016 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн явц:</u><br><br>Байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн самбараар болон биечилсэн хэлбэрээр албан хаагчдад хуулийн хугацаа сануулж, холбогдох хуулийн заалтыг таниулах, мэдүүлэг, мэдэгдэл мэдүүлэхтэй холбоотой анхаарах асуудлын талаар мэдээлэл, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | зөвлөгөө өгөх ажлыг тухай бүр гүйцэтгэж, мэдүүлэг, мэдэгдэл мэдүүлэх боломж нөхцлийг бий болгон ажиллаж байна. Хөрөнгө орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд мэдүүлэх талаар санамж бүхий захидлыг дотоод сүлжээний “Захидал”-аар албан хаагч бүрт 2 удаа (улиралд 1 удаа) илгээв. Тайлант хугацаанд их хэмжээний өөрчлөлт (2015+)-ийг 3 албан хаагч мэдүүлснийг бүртгэн авч, цахим системд баталгаажуулав.<br><br>2016 оны 06 сарын 24-ний өдрийн байдлаар, албан тушаалд томилохоор нэр дэвшүүлсэн 15 нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдэгдэл (ХАСУМ)-ийг бүртгэн авч, АТГ-т хүргүүлэн хянуулсан бөгөөд тэдгээрээс 8 нэр дэвшигчийг тухайн албан тушаалд томилсон байна. 2016 онд шинээр албан тушаалд томилогдсон 9 мэдүүлэг гаргагч албан хаагчид ХАСХОМ-ийг томилогдсоноос хойш (2015*) хуулийн хугацаанд мэдүүлэх талаар зөвлөгөө, дэмжлэгээр хангаг ажиллаж, авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах арга хэмжээ авч ажилласан. Уг албан хаагчид хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг шинээр мэдүүлснийг бүртгэн авч, цахим системд баталгаажуулав.<br><br>Тайлант хугацаанд 33 үнэлгээний хорооны гишүүдийн гаргасан 229 ашиг сонирхлын мэдэгдлийг бүртгэлээр хүлээн авч, цахим системд 136 АСМ-ийн мэдээллийг оруулав. Одоогоор 7 АСМ баталгаажаагүй, зарим мэдээлэл дутуу, тушаалаас овог зөрсөн зэрэг алдаа доголдолтой байсныг засуулахаар Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга нарт нь буцаав.<br><br>АСМ-үүдийг хуульд заасан хугацаанд гаргаж мэдэгдэх талаарх хуулийн хэрэгжилтийг хангуулах, дотооддоо хяналт тавьж, уг ажлыг эрчимжүүлэх зорилгоор Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга нараас ҮХ-ны гишүүдийн гаргасан АСМ-үүдийг АТГ-ын Мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд оруулуулахаар ЭБАТ-д бүртгүүлсэн байдлын мэдээг Нарийн бичгийн дарга тус бүрээр гаргаж, дотоод сүлжээгээр ил тод мэдээлэв.<br><br>“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар АТГ-аас ирүүлсэн 3 зөвлөмжийг www.able.mn дотоод сүлжээний ”Олон нийтийн” цэсэнд байршуулан, нийт албан хаагчдад мэдээлэн сурталчилсан. (Б-100%) |
| | - Засгийн газрын 2013 | Худалдан авах | ЗУХ | Засгийн газрын бодлогын баримт бичгүүд, холбогдох эрх зүйн актын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Арга хэмжээ 2.11.13.** Холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнан мэдээлэх | оны 322 дугаар тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаа, хуваарийн дагуу дээд шатны байгууллагад тайлагнан мэдээлж ажиллах,<br>- Хагас, бүтэн жилд ЗГХЭГ, ШСАА, Сангийн яаманд холбогдох тайлан мэдээллийг хүргүүсэн байна.<br>- Цахим систем, дотоод сүлжээгээр олон нийт, албан хаагчдад мэдээлэх, тухай бүр. | ажиллагааны газрын үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл дээд шатны байгууллага, иргэд, олон нийтэд ил тод мэдээлэгдэнэ. | | хяналтад авсан, холбогдох заалтын биелэлтийн тайланг 2015 оны жилийн эцсийн дүнгээр гаргаж, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан хугацаа, хуваарийн дагуу ЗГХЭГ, ШСАА, СЯ-нд 2016 оны 1/31, 1/237 тоот албан бичгээр тус тус хүргүүлэн тайлагнав. Үүнд:<br>1. МУ-ын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3 заалтын хэрэгжилт дунджаар 86,7 хувийн явцтай (өссөн дүнгээр),<br>2. МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2015 оны үндсэн чиглэлийн 1 заалтын биелэлт 90,0 хувийн гүйцэтгэлтэй,<br>3. Холбогдох эрх зүйн акт (дээд шатны тогтоол, шийдвэр)-ын биелэлт дунджаар 92,5 хувийн биелэлттэй байна. 2015 оны жилийн эцсийн дүнгээр нийт 3 төрлийн 23 шийдвэрийн 28 заалтын хэрэгжилтийг зохион байгуулан дүнг тайлан, мэдээнд тусгасан:<br>3.1. УИХ-ын 2 тогтоолын 2 заалтын хэрэгжилт – 95,0 хувь,<br>3.2. Засгийн газрын 9 тогтоолын 10 заалтын хэрэгжилт – 86,0 хувь,<br>3.3. Засгийн газрын хуралдааны 12 тэмдэглэлийн 16 заалтын хэрэгжилт – 96,3 хувь.<br>Эдгээр дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн заалтуудаас цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болж, хугацаа дууссан, хэрэгжилт нь тогтмолжин хэвшсэн, тус байгууллагад хамаарахгүй байх нийт 3 төрлийн 17 шийдвэрийн 22 заалтыг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан журмын 16 дахь заалт, Засгийн газрын хуралдааны 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 13 дугаар тэмдэглэлийн XIY.2.2 дахь заалтаар өгсөн үүрэг, чиглэлийн дагуу цаашид байнга хянаж, тайлагнах шаардлагагүй гэж үзэн хяналтаас хасуулах саналыг боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэв.<br>Тайлант хугацаанд, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn-д холбогдох эрх зүйн акт (дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэр)-ын 2015 оны жилийн эцсийн биелэлтийг заалт бүрээр оруулан, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулав. Засгийн газраас 95,91 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн.<br>Нийт дүнгээр дүгнэж танилцуулбал, (2016 оны 1-2 сард дүн гарч |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | дууссан): ХААГ-т нийт 25 бодлого, шийдвэрийн холбогдох 32 заалтын хэрэгжилт 2015 оны жилийн эцсийн дүнгээр 89,7 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнэгдсэн.<br><br>Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын цахим хуудас www.e-tender.mn, байгууллагын дотоод сүлжээ www.able.mn –нд байршуулан, олон нийт болон нийт албан хаагчдад ил тод мэдээлж, мэдээллээр хангав.<br><br>2016 он гарсаар шинээр батлагдсан дээд шатны байгууллагын 10 шийдвэрийг хүлээн авч, удирдлагын мэдээллийн цогц систем www.able.mn дотоод сүлжээний холбогдох цэсэнд байршуулан нийт албан хаагчдад танилцуулан сурталчилж, хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна.<br><br>Дээрх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны эхний хагас жилийн дүн гарч дуусаагүй байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 2.12.14.** Албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, Ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхижүүлэх | - Ажлын цаг ашиглалтыг сайжруулах “Хором бүрт хоцролтгүй хамт олон” сарын аян зохион байгуулах арга хэмжээний удирдамж гарган хэрэгжүүлэх, II, IY улиралд,<br>- Ёс зүйн хорооны ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу идэвхижүүлэн эрчимжүүлэх, жилдээ,<br>- Сахилга, хариуцлагыг өндөржүүлэх талаар арга хэмжээг тодорхойлон батлах, I улиралд,<br>- Хэрэгжилтийг хангах, жилдээ. | Сахилгын зөрчил буурч, албан хаагчдын цаг ашиглалт сайжирсан байна. Хууль, эрх зүйн зөрчил доголдолгүй хамт олон болсон байна. | ЗУХ, Ёс зүйн хороо | Ажлын цаг ашиглалтыг сайжруулах “Хором бүрт хоцролтгүй хамт олон” сарын аяны арга хэмжээг оны сүүлийн хагас жилд зохион байгуулахаар болсон. Ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор хяналт тавьж, 7 хоногийн удирдах ажилтны шуурхай хуралд нийт албан хаагчдын цагийн бүртгэлийг танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажилласнаар байгууллагын хэмжээнд ажлын цаг ашиглалт, сахилга дэг журам сайжирсан.<br><br>Ёс зүйн хорооны хурлыг 1 удаа зохион байгуулж, хуралдуулан 1 албан хаагчийн асуудалд дүгнэлт гаргасан. Тайлант хугацаанд сахилгын шийтгэлийг 2 албан хаагчид ногдуулав. Үүнд: Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 06/6263 дугаар бүхий “Арга хэмжээ авахуулах тухай” албан бичгийн дагуу “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Б/01 тоот тушаал гаргаж, 1 албан хаагчийн албан тушаал бууруулах, 1 албан хаагчийн албан тушаалын сарын цалинг 3 сарын хугацаагаар 30 хувь бууруулах арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлэв. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 2.13.15.** Албанд томилогдох, чөлөөлөгдөх албан хаагчдад төрийн болон албаны нууцтай | - Нууцын баталгаа гаргуулах,<br>- Зөвлөмж, зөвлөгөө, арга зүйгээр хангах,<br>- Жилдээ. | Төрийн нууцын тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, албан хаагчдын ёс суртахууны | ХХХэлтэс | Худалдан авах ажиллагааны газарт шинээр ажилд томилогдсон болон хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнээр дэвшин томилогдсон нэр бүхий 8 албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэх үедээ танилцсан баримт, материалтай холбоотой төрийн болон байгууллагын нууцыг задруулахгүй байх төрийн нууцын баталгаа бичгээр гаргуулан авч, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн. (Б-100%) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| танилцах, сахин мөрдөхөд чиглэсэн эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, нууцын баталгааг бичгээр гаргуулан авах ажлыг хэрэгжүүлэх | | ухамсар, хариуцлага дээшилнэ. | | |
| **Арга хэмжээ 2.14.16.** Байгууллагын дотоод хэлтсүүдийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг хангах, дүгнэж урамшуулах, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах | - Байгууллага, хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөө, албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх, гүйцэтгэлийг үнэлэх,<br>- Үнэлгээний мөрөөр урамшуулах, хариуцлага тооцох ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулах,<br>- Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг шийдвэрлэх,<br>- Улирал, хагас, бүтэн жилд. | Үр дүнд суурилсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.<br><br>Гүйцэтгэлийг бодитоор дүгнэж, үр дүнг тооцсон байна. | ЗУХ, ХХХэлтэс | Нийт 53 албан хаагч 2016 оны үр дүнгийн гэрээгээ холбогдох журамд заасан хугацаанд байгуулсан.<br><br>2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 стратегийн зорилт, 7 хөтөлбөрийн хүрээнд нийт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсантай холбогдуулан хэлтсийн албан хаагчид өөрт хамаарал бүхий заалтыг хэрэгжүүлэх ажлуудыг үр дүнгийн гэрээндээ нарийвчлан тусган хэрэгжүүлж байна. Хэлтсийн сар, улирал бүр хийх ажлын төлөвлөгөөг байгууллага, хэлтсийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж, биелэлтийг нь сар бүр тооцон, хяналт тавьж байна. 2016 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний хурлыг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдсан.<br><br>Худалдан авах ажиллагааны газрын хэлтсүүдийн 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэлтсийн дарга, албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн явц, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилтийн байдалд дотоод хяналт, шалгалт хийхээр 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/75 дугаар тушаал гарч, удирдамж, төлөвлөгөө батлагдсан. Энэхүү хяналт, шалгалтын хүрээнд байгууллагын төсөв, санхүү, хөрөнгийн үр өгөөж, ашиглалтад хяналт хийж, хэрэгжүүлэхээр тусгаад байна. Хяналт, шалгалтын ажил дуусаагүй байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 2.15.17.** Байгууллагын үйл ажиллагаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан, таниулж, мэдээлэх | - Мэдээ, мэдээлэл бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг зохион байгуулах,<br>- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуурыг хангах арга хэмжээ | Байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод мэдээлэгдэнэ. | ЗУХ, Бух хэлтэс | 2016 оны эхний хагас жилд Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаа болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг телевизээр 18, сониноор 8, ХААГ-ын www.e-tender.mn цахим хуудсаар 21, бусад цахим хуудсаар 5 мэдээ, мэдээлэл, давхардсан тоогоор нийт 52 мэдээ, мэдээлийг мэдээлэн сурталчилсан байна.<br><br>2016 оны 02 сарын 24-ний өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Шийдлийн цаг” уулзалтын хүрээнд тус байгууллагад ажиллаж, үйл ажиллагаатай танилцав. Уулзалтад холбогдох яам, агентлаг болон худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | авч хэрэгжүүлэх,<br>- Худалдан авах ажиллагааны үр дүнг олон нийтэд мэдээлэх,<br>- Хэвлэлийн хурал зохион байгуулах, 4 удаа,<br>- Жилдээ. | | | нэгж, албан байгууллагын төлөөллүүд оролцсон юм. Тус уулзалтад 9 телевиз (МҮОНТ, NTV, Парламент ТВ, UBS, Эх орон ТВ, VTV, MN25, TV10, ETV), 5 сонин (Өдрийн сонин, Өнөөдөр, Улс төрийн тойм, Монголын мэдээ, Үндэсний шуудан, МОНЦАМЭ), 8 цахим хуудас (www.24tsag.mn, www.bataar.mn, www.info.mn, www.montsame.mn, www.news.mn, www.time.mn, www.zaluu.com, www.zasag.mn)-ын сэтгүүлч, сурвалжлагч нар оролцож, Ерөнхий сайдын уулзалт, тус байгууллагын үйл ажиллагаар сурвалжлан олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэв.<br><br>ХААГ болон орон нутгийн Худалдан авах ажиллагааны албадын 2015 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтад шалгарсан компанийн ажлын гүйцэтгэл, 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын www.e-tender.mn цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн. (Б-100%) |
| **Хоёр. “Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих”** гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: | | | | |
| **ХӨТӨЛБӨР III**<br>**“Худалдан авах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулан хэрэгжүүлэх, тайлагнах”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 3.1.18.**<br>ХАА-ны мэргэжлийн байгууллагын зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шаардлагатай ТЭЗҮ, зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг захиалагчаас авах, Ерөнхий гэрээний ажлыг зохион байгуулах бэлтгэл хангах | - ХААГ-ын тухайн онд зохион байгуулах нийт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны бэлтгэл хангагдсан байх,<br>- I, II улиралд. | Нийт төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хүлээн авч, худалдан авах ажиллагаар зохион байгуулсан байна. | ТСХ | 2016 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор баталсан, тус байгууллагад худалдан авалтыг зохион байгуулах 73,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 43 төсөл, арга хэмжээнээс 36 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хүлээн авч худалдан авах ажиллагааны бэлтгэлийг 90,4 хувиар хангаснаар батлагдсан ажлуудын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж эхэлсэн.<br><br>Мөн Төсвийн ерөнхийлөн захирагч нараас 19.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа тус байгууллагад эрх шилжиж ирсэнээс бүх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шаардлагатай материалыг захиалагчаас хүлээн авч тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.<br><br>Мөн гадаад эх үүсвэр буюу Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих "Ухаалаг засаг" төслийн хүрээнд хэрэгжих 51 төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч, холбогдох баримт материал ирүүлсэн байгаа 2,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж эхэлсэн байна.<br><br>Ерөнхий гэрээний худалдан авах ажиллагаар зохион байгуулах бэлтгэл хангах ажлын хэсгийг ХААГ-ын даргын 2016 оны 01 дүгээр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | сарын 19-ний өдрийн А/07 тоот тушаалаар байгуулж, ажлын хэсэг Сангийн яам, “Мирим консалт” ХХК, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төлөөлөлтэй 2016 оны 01 дүгээр сарын 25-29-ний өдөр, 04 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд холбогдох албан хаагчдын хүрээнд уулзалт, зөвлөгөөнийг тус тус зохион байгуулсан. Уулзалт, зөвлөгөөн, ажлын хэсгийн дүгнэлт, шийдвэрийн дагуу Ерөнхий гэрээгээр "А4 бичгийн цаас", "Шатахуун" худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. Мөн Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Сангийн яам, ХААГ-аас Ерөнхий гэрээний журамд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдаж, тухайн журмыг шинэчлэн боловсруулахаар бэлтгэж байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 3.2.19.** Тендерийн урилга, зарыг нийтлүүлэх өдөр тутмын сонинг сонгон шалгаруулах | - Ажлын хэсэг байгуулах,<br>- Нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулах, I сард,<br>- Зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний тендерийн урилга, зарыг хуулийн хугацаанд шуурхай мэдээлэх,<br>- Урилга нийтлэгдсэн хэвлэлийн мэдээллээр архивын нэгж үүсгэх,<br>- Жилдээ. | Иргэн, аж ахуйн нэгж, олон нийт худалдан авах ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангагдсан байна. | ХААЗБХ, ЗУХ | ХААГ-аас 2016 онд зохион байгуулах төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын урилга, зарыг нийтлэх өдөр тутмын сониныг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог газрын даргын 2015 оны 11 сарын 30-ны өдрийн А/84 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хорооны Нарийн бичгийн даргаар ХААЗБХ-ийн мэргэжилтэн Б.Сэргэлэн ажилласан бөгөөд тус хэлтсээс хамтран ажиллав. Сонгон шалгаруулалтад оролцох урилгыг өдөр тутмын 11 сонинд хүргүүлснээс 5 сонин оролцох саналаа ирүүлсэн бөгөөд сонгон шалгаруулалтад Өдрийн сонин, Өнөөдөр, Улс төрийн тойм сонинууд шалгарч, 2016 оны 01 сарын 21-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Гадаадын оролцогчдод зориулж, UB Post сонинд тендерийн урилга, зарыг англи хэл дээр нийтлүүлэхтэй холбоотой шууд гэрээг байгуулав.<br><br>2016 оны 06 сарын 21-ний өдрийн байдлаар 32 тендерийн урилга, 5 зөвлөх үйлчилгээний тухай зарлал, 6 тендерийн урилгын залруулга, хугацаа сунгасан зар, 3 зарлалыг эдгээр өдөр тутмын сонинд, гадаадын этгээд оролцох тендерийн нийт 10 урилга, зөвлөх үйлчилгээний тухай зарыг UB post сонинд англи хэлээр нийтлүүлээд байна. (Б-100%) |
| **Арга хэмжээ 3.3.20.** ХААГ-ын зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт, төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр | - Улсын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан бий болох,<br>- Холбогдох дээд шатны байгууллагад шуурхай танилцуулагдах, | Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна. | ТСХ, ЗУХ | ХААГ болон 2015 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтад шалгарсан компанийн ажлын гүйцэтгэл, 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас www.e-tender.mn цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн. Мөн Худалдан авах ажиллагааны газрын 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан талаарх мэдээллийг бэлтгэж, Ардчилал, Монголын үнэн, Өнөөдөр сонинд 01 сарын 06-ны өдөр нийтлүүлэн олон нийтэд сурталчлан таниулж, 2016 оны 01 сарын 08-ны өдөр хэвлэлийн хурал зарлаж, 7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ил тод мэдээлэн тендерт оролцогчдын өрсөлдөх тэгш боломжийг хангах | - Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, 1 дүгээр сард,<br>- Гарын авлага гаргах, I, II улиралд. | | | ТВ, 1 сонин, 1 радиод Ахлах мэргэжилтэн Ц.Минжинхүү дэлгэрэнгүй мэдээлэл хийж, 2016 онд зохион байгуулах худалдан авах ажиллагаатай холбоотой төсөл, арга хэмжээнүүдийг танилцуулав.<br>Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгтгэн гаргахтай холбоотой гарын авлагыг Төлөвлөлт, судалгааны хэлтсээс боловсруулж байна.<br>Мөн Газрын цахим хуудас болох www.e-tender.mn -д "Ухаалаг засаг төсөл"-ийн хүрээнд 2015-2016 онд зохион байгуулагдах төсөл, арга хэмжээний худалдан авалтын төлөвлөгөөг ил тод байршуулж, олон нийтэд мэдээлсэн. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 3.4.21.**<br>Орон нутгийн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг ЗГХАА, ХААГ, аймаг, орон нутгийн цахим хуудсанд ил тод зарлан, өрсөлдөх тэгш боломж нөхцлийг бүрдүүлэх, хяналт тавьж, үр дүнг олон нийтэд мэдээлэх | - Улсын хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээний нэгдсэн сан бий болох.<br>- Холбогдох газруудад шуурхай танилцуулагдсан байх.<br>- Төлөвлөгөө батлагдсан тухай бүр. | Мэдээллийн ил тод байдал, нээлттэй байдал хангагдсан байна. | ЗУХ | Худалдан авах ажиллагааны орон нутгийн 21 нэгжийн зохион байгуулах аймаг, нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын баталсан 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Худалдан авах ажиллагааны газрын www.e-tender.mn, аймаг, нийслэл, дүүргүүдийн цахим хуудас, Худалдан авах ажиллагааны нэгжүүдийн цахим хуудсанд тус тус байршуулсан. Орон нутгийн нэгжүүдийн энэ талаарх мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа байдалд хяналт тавьж, ажиллав. (Б-100%) |
| **Арга хэмжээ 3.5.22.**<br>Улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээ, захиалагчаас эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах | - Улсын болон бүс нутгийн чанартай бараа, ажил, зөвлөх үйлчилгээний болон эрх шилжиж ирсэн ажлын худалдан авах ажиллагааг Ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байх,<br>- Жилдээ. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. | ХААЗБХ | Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжигдэх нийт 73,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 43 төсөл, арга хэмжээ, мөн Төсвийн Ерөнхийлөн захирагч нараас эрх шилжиж ирсэн 19,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээ, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих 2,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ, нийт 94,4 тэрбум төгрөгийн төсөвтэй 60 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ХААГ-т холбогдох хууль, журмын дагуу 2016 онд зохион байгуулж байна.<br>Эдгээр 60 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад өнөөдрийн байдлаар нийт 120 багц болон задарч байгаа ба эдгээрийн худалдан авах ажиллагааны явцыг дор танилцуулбал:<br>1. Гэрээ байгуулсан – 21, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 2. Гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн – 35,<br>3. Гэрээ байгуулах мэдэгдлийг оролцогчид хүргүүлсэн – 17,<br>4. Үнэлгээний тайлан, зөвлөмж бэлтгэж байгаа – 14,<br>5. Нээлт хийсэн, үнэлгээ хийж байгаа – 7,<br>6. Тендер зарласан, нээлт хийх хугацаа болоогүй байгаа – 5,<br>7. Дахин зарласан – 2,<br>8. Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа – 1,<br>9. ТЕЗ-аас зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар ирүүлээгүй байгаа - 5 ,<br>10. Баримт бичиг дутуу - 2,<br>11. Захиалагч (холбогдох ТЕЗ) жагсаалтаас хасуулсан, хасуулахаар бэлтгэж байгаа - 9,<br>12. Хүчингүй болсон мэдэгдлийг оролцогчдод хүргүүлсэн – 2.<br><br>2016 онд ХААГ-т зохион байгуулагдаж байгаа 60 төсөл, арга хэмжээний 120 багц ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэвэл,<br><br>o 60,8 хувь нь бүрэн хэрэгжсэн,<br>o 25,8 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулагдаж байгаа,<br>o 5,8 хувь нь захиалагч - Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тендер шалгаруулалтад шаардлагатай зураг төсөл, холбогдох материал ирүүлээгүй, хүлээгдэж байгаа,<br>o 7,5 хувь нь ТЕЗ-ийн санаачилгаар хасагдсан шалтгаанаар хэрэгжих боломжгүй байна.<br><br>ХААГ-т зохион байгуулагдаж дууссан худалдан авах ажиллагааны үр дүнд (2016 оны 05 сарын 24-ний өдрийн байдлаар) улсын төсөвт 1,3 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан тооцоо гарч байна.<br><br>(ХШ-90%) |
| **Арга хэмжээ 3.6.23.** Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, худалдан авах ажиллагааг мэргэжлийн байгууллагад 100 хувь, орон нутгийн нэгжид 80- | - Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, орон нутгийн нэгжүүдийн цахим тендер шалгаруулалт зохион байгуулах боломж, нөхцлийг хангах, | Захиалагч байгууллагын тендер шалгаруулалт зохион байгуулах зардал буурч, төрийн байгууллагуудын уялдаа холбоо | МТИХ, ЗУХ, ХААЗБХ | Шадар сайд, аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнд “Худалдан авах ажиллагааны албыг цахим хэлбэрээр тендер зарлах боломж бүрдүүлэхэд Засаг даргын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах тухай” тусгуулан, орон нутгийн нэгжүүдэд 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнийхээ 80 хүртэлх хувийг цахимаар зохион байгуулах тухай ХААГ-ын даргын албан бичгийг тус тус хүргүүлэв.<br><br>ХААГ нь “Цахим худалдан авах ажиллагааны систем”-ийн аюулгүй, хэвийн үйл ажиллагааг хангаан ажилласны дүнд уг системийг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| аас дээш хувь цахим хэлбэрээр зохион байгуулах | - Орон нутгийн нэгжийг чадавхижуулах,<br>- ААНБ-уудыг чадавхижуулах<br>- Жилдээ. | сайжирна. Цахим мэдээлэл солилцоонд ахиц гарсан байна. | | ашиглалт орон нутагт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 45 хувиар, нийслэлийн ХААГ, дүүргийн албадад 7,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тус мэргэжлийн байгууллагад зохион байгуулагдаж байгаа худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн. Тухайлбал, 2016 оны 06 сарын 21-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 1588 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулан давхардсан тоогоор 6403 тендерийн саналыг хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад цахимаар зарлан зохион байгуулсан ажил 2 дахин, түүнд ирүүлсэн тендерийн саналын тоо 3 дахин өссөн дүнтэй байгаа нь цахим системийн ашиглалт ахисныг илтгэж байна.<br><br>Орон нутгийн худалдан авах ажиллагааны 31 нэгж өмнөх жилд дунджаар зохион байгуулах нийт ажлын 30 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулж байсан бол 2016 оны эхний хагас жилийн дүнгээр нийт ажлын 58 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулаад байна. Хөвсгөл, Орхон, Өмнөговь, Дундговь, Булган, Дорноговь, Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны албад цахим системийн хэрэглээг 70-100 хүртэл хувьд хүргэсэн.<br><br>2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар, орон нутгийн Худалдан авах ажиллагааны албад давхардсан тоогоор 970 (1602 - цахим системд зарлагдсан нийт тоо) тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Аймгуудаас хамгийн их нь Хөвсгөл 285, Орхон аймаг 166 тендер шалгаруулалтыг цахим хэлбээр зарлан зохион байгуулсан бол хамгийн бага нь Төв аймаг 9, Ховд аймаг 8, Завхан аймаг 4 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан дүнтэй байна. Нийслэлийн ХАААГ, дүүргүүдийн ХААА-д давхардсан тоогоор 77 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан бол Баянзүрх дүүргийн ХАААлба цахим системд бүртгэлтэй боловч, цахим тендер шалгаруулалтыг одоогоор зохион байгуулаагүй байна.<br><br>Цахим худалдан авах ажиллагааны системд 2016 оны 06 сарын 17-ны өдрийн байдлаар урилга – 42, тодруулга, зарлал – 36, Тендерт оролцогч ААН-ийн материал (CD) - 30 бичиж, тус тус нийтэлсэн байна.<br><br>Нийслэлийн ХААГ болон дүүрэг, орон нутгийн ХААА-дад нээлт хийх болон үнэлгээ хийхэд шаардлагатай тусламжийг шуурхай үзүүлэн ажилласан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Өдөр тутмын үйл ажиллагаагаар нийслэл, орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, нийслэл болон орон нутагт байрлалтай тендерт оролцогч аж ахуй нэгж, байгууллагуудад цахим системтэй холбоотой мэдээлэл, заавар, зөвлөгөөг утсаар, уулзалтаар, мөн цахим хэлбэр (TeamViewer)-ээр тус тус өгч ажилласан бөгөөд зөвхөн 70110422, 70139970 утсаар 6715 удаа нийт 574950 минутын (2016.06.08-ны байдлаар) зөвлөгөө, арга зүйг захиалагч болон нийлүүлэгч байгууллагуудад хүргэж ажилласан үзүүлэлттэй байна.<br><br>Орон нутгийн ХАААлбаны мэргэжилтэн, албан хаагчдад өдөр тутмын үйл ажиллагаагаар дамжуулж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч гарын авлага, мэдээллээр ханган, хувийн нууцлалын код олгож байна. Тайлант хугацаанд нийт 116 захиалагч, 1537 орчим ААН, нийлүүлэгч байгууллагыг цахим тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай ханган ажилласан. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 3.7.24.** Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх | - Үнэлгээний хороод холбогдох цахим хуудсанд үр дүнг тухай бүр нийтлэх,<br>- Шууд гэрээний үр дүн, шалгарсан оролцогчийн материалыг цахим хуудсанд нийтлэх боломжийг бий болгох,<br>- Үр дүн нийтэлж байгаа байдалд хяналт тавих,<br>- Гэрээ байгуулсан ААН-үүдийн бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулах,<br>- Жилдээ. | Тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээллийн ил тод байдал хангагдана. | ХААЗБХ, МТИХ, ХХХэлтэс | Цахим худалдан авах ажиллагааны www.meps.gov.mn систем дээр 2016 оны 06 сарын 17-ны өдрийн байдлаар тендер шалгаруулалт дуусч, шалгарсан компанитай захиалагчаас гэрээ байгуулсан 7 ажлын үр дүн, шалгарсан компанийн материалыг ил тод мэдээлээд байна. Үүнд:<br><br>2015 онд зохион байгуулсан:<br>1. Сургуулийн барилгын өргөтгөл (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 48 дугаар сургууль),<br>2. Сургуулийн барилгын өргөтгөл Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 84-р сургууль,<br>3. “Албан хаагчдын болон ялтны нормын хувцас, хэрэглэл нийлүүлэх” (Багц 10, 13).<br><br>2016 онд зохион байгуулсан:<br>1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг),<br>2. Хот суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа (Өвөрхангай, Гучин-Ус сум),<br>3. "Төв замаас гордок хүртэлх хатуу хучилттай авто зам, 1км (Улаанбаатар, Налайх дүүрэг)”,<br>4. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэл (Увс, Өлгий)”.<br>(ХШ-70%) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Арга хэмжээ 3.8.25.** ХААГ, орон нутгийн нэгжүүдийн зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайланг нэгтгэн гаргаж, дүнг холбогдох байгууллагуудад танилцуулах | - Нийт төсөл, арга хэмжээний Худалдан авах ажиллагааны явц, үр дүнг ЗГХЭГ, Шадар сайд, Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэн тайлагнаж, олон нийтэд мэдээлсэн байх,<br>- Үр дүнг дүгнэж, байгууллагын тайлан, мэдээнд тусгасан байх,<br>- 2015 оны жилийн эцэс, 2016 оны улирал бүрийн тайлан гаргах. | Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны явцын дүн, мэдээллээр дээд шатны байгууллагыг хангасан байна. | ХХХэлтэс, ТСХ ЗУХ | ХААГ-ын зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайланг Сангийн сайдын 2007 онд баталсан журмын дагуу 2015 оны жилийн эцсийн байдлаар болон 2016 оны эхний хагас жилийн дүнгээр тус тус гарган 2 удаа Сангийн яаманд хүргүүлэв. ХААГ-ын зохион байгуулсан худалдан авах ажиллагааны явцын мэдээг Засгийн газрын цахим хуралд мэдээлүүлж, захиалагчдыг худалдан авах ажиллагаанд шаардлагатай баримт, материалыг яаралтай ирүүлж, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах боломж олгох талаар мэдээлүүлж, Засгийн газрын зүгээс шаардлага тавиулах зорилгоор ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т 2 удаа хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны явцыг Монгол Улсын Шадар сайдаар дамжуулан Засгийн газрын хуралдаанд 1 удаа мэдээлүүлж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг цаг алдалгүй, шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах талаар холбогдох байгууллагад үүрэг, чиглэл өгүүлсэн.<br><br>Худалдан авалтын сарын мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор, улирал бүрийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор ирүүлэх тухай ХААГ-ын даргын албан бичгийг орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдэд хүргүүлсэн.<br><br>Нэгжүүдийн худалдан авалтын 1 дүгээр улирлын тайланг хүлээн авч нэгтгэв. 2016 онд нийт 196,6 тэрбум төгрөгийн 1690 (100%) төсөл, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс 2016 оны 1-р улирлын байдлаар, 108,3 тэрбум төгрөгийн 915 (40%) төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдаж, 4,9 тэрбум төгрөгийн 90 (8%) төсөл, арга хэмжээний үнэлгээ хийгдэж, 18,3 тэрбум төгрөгийн 99 (13%) төсөл, арга хэмжээний тендер хүлээн авч, 30,4 тэрбум төгрөгийн 284 (11%) төсөл, арга хэмжээ зарлагдахаар бэлтгэгдэж байгаа явцтай байна. 32,3 тэрбум төгрөгийн 302 (28%) төсөл, арга хэмжээ зохион байгуулагдаагүй хүлээгдэж байна.<br><br>Нэгжүүдийн худалдан авалтын мэдээ, тайланг тухай бүр шаардлагатай байгууллагад хүргүүлэн, холбогдох танилцуулга, мэдээлэлд тусгуулж, олон нийтэд мэдээлсэн.<br><br>2016 онд Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж буй орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг тус бүрээр гарган, худалдан авалтын явцын мэдээг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар гарган 21 аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, 21 аймгийн Засаг дарга, Худалдан авах ажиллагааны |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | албадад тус тус хүргүүлэхээр бэлтгэсэн. Уг мэдээллийг 2016 оны эхний хагас жилийн дүнгээр тодотгон гаргаж хүргүүлэхээр бэлтгэж байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 3.9.26.** ХААГ-аас 2017 онд зохион байгуулах улсын болон бүсийн чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, Ерөнхий гэрээгээр 2017 онд худалдан авах барааны жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор батлуулах | - Захиалагчаас санал авч нэгтгэх,<br>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгах,<br>- Засгийн газрын шийдвэр, жагсаалтын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж, батлуулах,<br>- IY улиралд. | Хуулийн хугацаанд багтаан жагсаалтыг батлуулсан байна. | ТСХ, ЗУХ | Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр улсын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс ХААГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтыг Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 455 дугаар тогтоолоор батлуулав.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 61,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээ, Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжигдэх 11,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ, нийт 11 Төсвийн Ерөнхийлөн захирагчид хамаарах 73,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 43 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газарт 2016 онд зохион байгуулахыг уг тогтоолоор даалгасан. Мөн энэхүү тогтоолоор төсвийн байгууллагын урсгал зардлаар худалдан авдаг 4 төрлийн бараа (бичгийн цаас, бензин, компьютер, принтерийн хор)-г Ерөнхий гэрээ байгуулах журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг ХААГ-т даалгав. Тогтоолоор баталсан ажлуудыг ХААГ-т 2016 оны үйл ажиллагаагаар хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2017 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт батлуулах хугацаа болоогүй. (ХБ.) |
| **Арга хэмжээ 3.10.27.** 2017 онд ХААГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг Худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах | - Батлагдсан жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрийг тусгасан Төсвийн ерөнхийлөн захирагч, ХААГ-ын хамтарсан төлөвлөгөө батлах,<br>- Ерөнхий төлөвлөгөөг Шадар сайдаар батлуулсан байх,<br>- IY улиралд. | Хуулийн хугацаанд багтаан хэрэгжүүлсэн байна. | ТСХ | 2017 онд ХААГ-т зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт, Ерөнхий төлөвлөгөө батлуулах хуанлийн хугацаа болоогүй. (ХБ.) |
| **Арга хэмжээ 3.11.28.** Худалдан авах | - “Шилэн тендер 2016” Өдөрлөг, арга | Худалдан авах ажиллагаа, | ХААЗБХ Бүх хэлтэс | 2016 оны 02 сарын 24-ний өдөр Монгол улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Шийдлийн цаг” уулзалтын хүрээнд тус байгууллагад |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ажиллагааны салбар, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах нээлттэй өдөрлөг зохион байгуулах | хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлах,<br>- Удирдлага, зохион байгуулалтаар хангаж, холбогдох газар, албыг хамруулах,<br>- Жилд 2 удаа зохион байгуулна. | байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод мэдээлэгдэнэ. | | ажиллаж, үйл ажиллагаатай танилцав. Уулзалтад холбогдох яам, агентлаг болон худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж, албан байгууллагын төлөөллүүд оролцсон юм. Тус уулзалтад 9 телевиз (МҮОНТ, NTV, Парламент ТВ, UBS, Эх орон ТВ, VTV, MN25, TV10, ETV), 5 сонин (Өдрийн сонин, Өнөөдөр, Улс төрийн тойм, Монголын мэдээ, Үндэсний шуудан, МОНЦАМЭ), 8 цахим хуудас (www.24tsag.mn, www.bataar.mn, www.info.mn, www.montsame.mn, www.news.mn, www.time.mn, www.zaluu.com, www.zasag.mn)-ын сэтгүүлч, сурвалжлагч нар оролцож, Ерөнхий сайдын уулзалт, тус байгууллагын үйл ажиллагааг сурвалжлан олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэв.<br><br>Монгол Улсын Засгийн газраас 2016 оныг “Хэрэглэгчийн жил” болгон зарласантай холбогдуулан тус байгууллага “Хэрэглэгчийн жил”-ийн ажлын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг Шадар сайдын Ажлын албанд нэг удаа тайлагнав. “Хэрэглэгчийн жил”-ийн нээлтийг Эрүүл мэнд, спортын яам, Шадар сайдын харьяа 6 агентлагтай хамтран 2016 оны 01 сарын 29-ны өдөр “Нэгэн дээвэр дор” нэртэйгээр зохион байгуулав. Хэрэглэгчийн жилийн ажлын хүрээнд зохион байгуулсан Шадар сайдын харьяа байгууллагуудын албан хаагчдын спортын нөхөрсөг арга хэмжээнд оролцож, хэрэглэгчийн төлөө үйл ажиллагаагаа нэгтгэн ажиллахаа илэрхийлэв.<br><br>2016 оны 03 сарын 15-ны өдөр Чингис хааны талбайд зохион байгуулагдсан “Олон улсын хэрэглэгчийн өдөр”-т зориулсан нээлттэй өдөрлөгийн арга хэмжээнд тус байгууллага идэвхитэй оролцон байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, хэрэглэгч, олон нийтэд мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлэв.<br><br>Нээлттэй өдөрлөгийн үеэр Худалдан авах ажиллагааны газраас иргэд, хэрэглэгчдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад 50 хувийн хөнгөлөлттэй үнээр бүртгэх, аж ахуйн нэгжүүдэд нууцлалын код өгөх, түүнчлэн 2015 онд Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан тендер шалгаруулалтад амжилттай оролцож шалгарсан дотоодын үйлдвэрлэгчдийн төлөөлөл болох “Дархан нэхий” ХХК, “Амно” ХХК, “Зорбион” ХХК өөрсдийн үйлдвэрлэж нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнээ сурталчлах ажлыг зохион байгуулав. Мөн энэ үеэр Худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнгийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг 50 гаруй иргэнээс авч, судалгааны дүнгийн дагуу иргэдэд чиглэсэн тодорхой ажлыг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулан ажиллаж байна. (Б-100%) |
| **ХӨТӨЛБӨР IY**<br>**“Хяналт, шалгалт, дотоод аудитын механизмыг боловсронгуй болгож, худалдан авах ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 4.1.29.**<br>Хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах | - Төлөвлөгөөнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дотоод аудит, ХШҮ-ний ажлыг тусгасан байх,<br>- Хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах,<br>- Хийсэн хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх,<br>- Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, үр дүнгийн талаар улирал, хагас жил, жилээр мэдээлэх. | Хяналт, шалгалтын ажлын үр нөлөө сайжирч, байгууллагын үйл ажиллагаа болон худалдан авах ажиллагаанд гарч болох зөрчил, доголдол арилж, эрсдэлгүй ажилласан байна. | ХХХэлтэс | Худалдан авах ажиллагааны газрын 2016 оны Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг баталж, байгууллагын www.e-tender.mn цахим хуудсанд 2016.03.28-ны өдөр байршуулан олон нийтэд ил тод мэдээлэн танилцуулаад байна. Уг хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд хэлтсүүдийн I улирлын төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явцад хяналт тавих ажлыг зохион байгуулан ажилласан. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 4.2.30.**<br>Худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн мэдээллийн санд хяналт тавьж, худалдан авах ажиллагааны үйл явцад мониторинг хийх | - Мэдээллийн санд мониторинг хийж, зөвлөмж өгөх,<br>- Гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шийдвэр гарсан ажлуудаас улирал бүр түүвэрлэн хяналт, шалгалт хийж, зөвлөмж өгөх,<br>- Худалдан авах ажиллагаа шуурхай, шударга зохион байгуулагдсан байх,<br>- Жилдээ. | ХАА-ны мэргэжлийн байгууллага болон орон нутгийн нэгжүүдээс зохион байгуулж буй худалдан авах ажиллагааны явцын талаарх мэдээллийн сан үүсч, иргэд олон нийтэд цахим системээр ил тод мэдээлэгдсэн байна. | МТИХ, ХХХэлтэс | “Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд шинээр хийгдэж байгаа Худалдан авах ажиллагааны нэгдсэн систем болох www.tender.gov.mn–д шаардлагатай мэдээллүүдийг холбогдох байгууллагуудаар гаргуулан хүлээн авч, ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр системийн боловсруулалтад оруулах ажлыг хийсэн. Үүнд:<br>Тусгай зөвшөөрөл олгодог 36 төрийн байгууллагаас олгодог тусгай зөвшөөрлийн мэдээллийг болон тэдгээрийг эзэмшигч ААН, байгууллагын мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийн системд оруулахад бэлэн болгосон, Энэхүү мэдээллийг системд бүртгэж, тухайн олгох эрх бүхий байгууллага нь мэдээлэлдээ өөрсдөө засвар оруулж байх нь тендерийн материалд ААН-ээс хуурамч тусгай зөвшөөрлийн мэдээлэл ирдэг байдлыг хаах үр дүнтэй юм.<br>Худалдан авах ажиллагаа зохион байгуулж буй бүх захиалагч байгууллагууд тендерт оролцогч аж ахуй нэгжүүдийн төлсөн тендерт оролцох хураамжийг шууд өөрсдийн дансанд төвлөрүүлэх нөхцөлийг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | бүрдүүлж, байгууллага бүрд дансыг тохируулж өгөх зорилгоор 21 аймгийн худалдан авах ажиллагааны албанаас тухайн аймгийн захиалагч байгууллагуудын орлогын дансыг хүлээн авч, оруулах ажлыг хийв.<br><br>Худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг, www.pmmis.mof.gov.mn системд бүртгэлтэй нийт 768 захиалагч байгууллагын 2016 онд зохион байгуулах 5443 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний мэдээллийг www.tender.gov.mn системд оруулж, илгээх, төсвийн ерөнхийлөн захирагч болон сангийн яамаар батлах ажлыг хийв.<br><br>Монгол Улсын хэмжээнд тендер шалгаруулалтаар худалдан авч болох 10114 бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, каталогийг оруулсан.<br><br>2016 онд тус байгууллагын хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны жагсаалт дахь 36 төсөл, арга хэмжээ болон эрх шилжиж ирсэн 13 ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг уг нэгдсэн системд оруулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг уг системд, санамсаргүй сонголтын аргаар сонгон байгуулж, зарласан тендерийн урилгыг нийтлэх ажлыг гүйцэтгэж байна.<br><br>Эдгээр үйл явцыг гүйцэтгэж, системийн хөгжүүлэлтийг хийх явцад тус байгууллагын МТИХ-ээс системийн мэдээллийн санд мэргэжлийн зүгээс хяналт тавин, гарсан доголдол, асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж, хэвийн үйл ажиллагааг хангаж байна.<br><br>Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан, зохион байгуулж буй худалдан авах ажиллагааны процесст хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд байгуулагдсан үнэлгээний хорооны үйл ажиллагааны явцад хяналт хийж, үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт болон газрын удирдлагад дүнгэлт зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нар худалдан авах ажиллагааны цахим хуудсанд тендерийн урилга, материалыг цаг алдалгүй түргэн шуурхай мэдээллсэн эсэх, шалгарсан аж ахуйн нэгжийн тендерийн материал, үр дүнг цахим худалдан авах ажиллагааны системд ил тод мэдээлсэн байдалд хяналт, шалгалт хийсэн үр дүнг 2 удаа үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт болон ХААЗБХэлтсийн даргад дүгнэлт, зөвлөмжөөр хүргүүлсэн. Хяналт хийсэн мэдээг 7 хоног бүр удирдах ажилтны |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | шуурхай хуралд танилцуулан мэдээлсэн.<br>Үнэлгээний хорооны гаргасан тайлан, зөвлөмжид газрын даргаас хяналт тавих эрхээ XXXэлтэст шилжүүлсэн нь гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн аж ахуйн нэгжийн тендерийн материалд тусгайлан хяналт хийх шаардлагаггүй болсон гэж үзэн түүвэр хяналт хийхгүй байгаа болно. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 4.3.31.** Хэлтэс, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнд мониторинг, үнэлгээ хийж, дүгнэлт гарган, авах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх | - Хэлтсүүдийн үйл ажиллагаа, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээний биелэлтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,<br>- Дүгнэлт хийж, авах арга хэмжээний талаар Даргын зөвлөлд танилцуулах,<br>- Зөвлөмж, зөвлөгөө өгөх,<br>- Хагас, бүтэн жилд. | Дотоод хяналт, шалгалтын ажлыг хагас, бүтэн жилээр хийсэн байна. | XXXэлтэс | Худалдан авах ажиллагааны газрын хэлтсүүдийн 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэлтсийн дарга, албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийн явц, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилтийн байдалд дотоод хяналт, шалгалт хийхээр 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/75 дугаар тушаал гарч, удирдамж, төлөвлөгөө батлагдсан. Энэхүү хяналт, шалгалтын хүрээнд байгууллагын төсөв, санхүү, хөрөнгийн үр өгөөж, ашиглалтад хяналт хийж, хэрэгжүүлэхээр тусгаад байна. Хяналт, шалгалтын ажил дуусаагүй байна. (ХШ-50%) |
| **ХӨТӨЛБӨР Ү**<br>**“Гадаад хамтын ажиллагааг бэхжүүлж, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай харилцаа холбоо тогтоон, хөрөнгө оруулалтыг дэмжих”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 5.1.32.** Төрийн өндөр албан тушаалтнуудын гадаад айлчлалын үеэр байгуулагдах гэрээ хэлэлцээрт салбарын чиглэлийн асуудлыг тусгуулах | - Гадаад хамтын ажиллагааны гэрээнд салбарын асуудал тусгагдсан байх.<br>- Хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан байх.<br>- Жилдээ. | Салбарын асуудлаар гадаадын улс орнуудтай хамтран ажиллах боломж бүрдсэн байна. | ЗУХ, ТСХ | БНСУ-д 2016 оны 03 сарын 30-аас 04 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “COPEX-2016” олон улсын үзэсгэлэнд оролцох Монгол Улсын Засгийн газрын ахлах референт Н.Батсууриар ахлуулсан Засгийн газрын төлөөллийн бүрэлдэхүүнд тус байгууллагын дарга Н.Отгонбаяр, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ж.Жаргалсайхан нар орж, БНСУ-д айлчлан төрийн худалдан авах ажиллагааны сүүлийн үеийн онцлогийн талаарх мэдээлэл, туршлагатай танилцав. БНСУ-ын Засгийн газар, Худалдан авах ажиллагааны байгууллагаас 17 дахь жилдээ зохион байгуулж байгаа уг арга хэмжээний үеэр БНСУ-ын Шадар сайд, парламентийн гишүүд болон хувийн хэвшлийн төлөөлөл болсон томоохон компаниудын төлөөлөлтэй ажил хэргийн уулзалтуудыг хийв. Мөн Gyeonggi-do хотын дарга болон Засаг захиргааны төлөөлөлтэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хийсэн албан ёсны уулзалтын үеэр цаашид 2 улсын хамтын ажиллагаа, тэр дундаа худалдан авах ажиллагааны салбарт хамтран ажиллаж, нэн тэргүүнд цахим худалдан авалт, ерөнхий гэрээ, ногоон худалдан авах ажиллагааг онцлон туршлага солилцох талаар яриа хэлцэл хийв. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 5.2.33.** Худалдан авах ажиллагааны чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх талаар хамтран ажиллах | - Олон улсын хамтын ажиллагаа өргөжсөн байх.<br>- Жилдээ. | Худалдан авах ажиллагаанд шинэ туршлага нэмэгдэж, мэргэжлийн байгууллагын албан хаагчид чадавхижсан байна. | ЗУХ, ТСХ | ХААГ нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, БНСУ-ын хамтын ажиллагааны агентлаг КОЙКА зэрэг олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллав. Энэ хүрээнд Дэлхийн банкнаас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдийг чадавхжуулахад чиглэсэн сургалтад 8 албан хаагчийг хамруулав. Худалдан авах ажиллагааг Ерөнхий гэрээний журмаар зохион байгуулах чиглэлээр Испани улсын Барселонад зохион байгуулагдсан сургалт-семинарт 3 албан хаагч ЕСБХБанкны дэмжлэг, санхүүжилтээр хамрагдсан. Мөн БНСУ-д зохион байгуулагдсан “COPEX-2016” олон улсын үзэсгэлэнд оролцох Монгол Улсын Засгийн газрын төлөөллийн бүрэлдэхүүнд тус байгууллагын удирдлага, гадаад харилцааны мэргэжилтэн нар орж, БНСУ-д айлчлан Төрийн худалдан авах ажиллагааны сүүлийн үеийн онцлогийн талаарх мэдээлэл, туршлагатай танилцав.<br><br>Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр 2016 онд боловсрол, эрүүл мэндийн салбарт хэрэгжих нийт 50,0 сая ам.долларын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг ХААГ-т гүйцэтгүүлэхээр эдгээр олон улсын байгууллагатай тохирсон. Дэлхий банкны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа Засгийн газрын “Ухаалаг засаг” төслийн 2,1 тэрбум төгрөгийн төсөвтэй 4 ажлын худалдан авах ажиллагааг ХААГ-т зохион байгуулж эхэлсэн. (Б-100%) |
| **Гурав. “Худалдан авах ажиллагаанд менежментийн шинэлэг чиг хандлага, ур чадварыг нэвтрүүлэх”** гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: | | | | |
| **ХӨТӨЛБӨР YI**<br>**“Худалдан авах ажиллагааны олон улсын хөгжлийн чиг хандлагыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 6.1.34.** Гадаадын улс орнуудын худалдан авах ажиллагааны чиг хандлага, хууль, эрх зүй, цахим худалдан авах | - 1-5 орны худалдан авах ажиллагаа, системийн харьцуулсан дүгнэлт хийсэн байх,<br>- Шинэ ололт, чиг | Харьцуулж хөгжлийн түвшинг тодорхойлсон байна. Дүгнэлт гаргасан байна. | МТИХ, ТСХ, XXXэлтэс | Худалдан авах ажиллагааны олон улсын чиг хандлагад судалгаа хийсний үндсэн дээр БНСУ-ын ногоон худалдан авалтын үе шатлал, түүнийг хэрэгжүүлэх нөхцөл бололцооны талаарх судалж, "Цахим худалдан авах ажиллагааны II үе шат" хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд хэрэгжих цахим дэлгүүрийн барааны каталоги хэсэгт нэвтрүүлэх бололцоотой сайн туршлагын талаар БНСУ-ын цахим |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ажиллагааны системийн талаар судалгаа хийж, сайн туршлагыг нэвтрүүлэх | хандлага, сайн туршлагыг судлах,<br>- Нэвтрүүлж болох сайн туршлагын талаар дүгнэлт хийх,<br>- Жилдээ. | | | дэлгүүрийн барааны каталогид судалгаа хийж байна.<br>БНСУ-д 2016 оны 03 сарын 30-аас 04 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “COPEX-2016” олон улсын үзэсгэлэнд оролцох Монгол Улсын Засгийн газрын ахлах референт Н.Батсуурьиар ахлуулсан Засгийн газрын төлөөллийн бүрэлдэхүүнд тус байгууллагын дарга Н.Отгонбаяр, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ж.Жаргалсайхан нар орж, БНСУ-д айлчлан төрийн худалдан авах ажиллагааны сүүлийн үеийн онцлогийн талаарх мэдээлэл, туршлагатай танилцав.<br>Гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудын туршлага судлах, хамтран ажиллах боломжтой эсэх асуудлыг судлахаар Австрали, Канад, ХБНГУ, Хонг Конг, Япон, Сингапур, Англи, БНХАУ, Данийн Вант улс, Франц, Италь, ОХУ, Өмнөд африкийн БНУ зэрэг улс орнуудын холбогдох байгууллагад албан ёсны хүсэлт тавьж, цахим шуудан илгээсэн. Сингапурын холбогдох байгууллагаас албан хаагчид болон төлөөлөгчдийн асуудлаар хамтран ажиллах боломжгүйгээ илэрхийлсэн хариу ирүүлсэн, бусад байгууллагаас хариу ирээгүй байна.<br>Ерөнхий гэрээний журмын төслийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Европийн сэргээн босголт, хөгжлийн банкны зөвлөхийн баг 2016.04.25-аас 29-ний өдрүүдэд Худалдан авах ажиллагааны газарт ажилласан. Гадаадын зөвлөхийн багаас шатахуун, бичгийн цаас худалдан авах ерөнхий гэрээний үнэлгээний хорооны гишүүдэд ерөнхий гэрээг амжилттай хэрэгжүүлж буй Португал, Гүрж улсын сайн жишиг, туршлагын талаар сургалт явуулж, дээрх бүтээгдэхүүний худалдан авах ажиллагаанд анхаарах асуудлын талаар зааварчилгаа өгсөн. (ХШ-70%) |
| **Арга хэмжээ 6.2.35.** Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийж буй гадаад орнуудын туршлагыг судалж, ХААГ-ын албан хаагчдад таниулан сурталчлах | - Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийж буй гадаадын 2-3 орны туршлагыг судалсан байх.<br>- Мэдээлэл цуглуулан, танилцуулга бэлтгэх,<br>- Сургалт зохион байгуулсан байх.<br>- I улиралд. | Ерөнхий гэрээний дагуу шинэ оновчтой арга туршлагын талаар мэдээлэлтэй болсон байна. | ТСХ | Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банкнаас Испани улсын Барселона хотод Ерөнхий гэрээний сайн туршлагаас суралцах сургалтад 2016 оны 04 сарын 03-аас 04 сарын 08-ны өдрүүдэд МТИХ-ийн дарга Д.Лхамсүрэн, Ахлах мэргэжилтэн Н.Цэрэнсамбуу, ХХХэлтсийн мэргэжилтэн Д.Номингэрэл нар оролцов. (ХШ-70%) |
| **Арга хэмжээ 6.3.36.** | - Батлагдсан стандарт | Худалдан авах | ТСХ | IY улиралд гүйцэтгэхээр төлөвлөж байгаа. Хугацаа болоогүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Худалдан авах ажиллагааны чиглэлээр батлагдсан ISO-10845 стандартыг албан хаагчдад сурталчлан таниулах | болон тендерийн жишиг баримт бичгүүдийг харьцуулан судалсан байх.<br>- Албан хаагчдад танилцуулсан байх.<br>- Жилдээ. | ажиллагааны стандартыг сурталчлан танилцуулсан байх. | | хүлээгдэж байна. (ХБ.) |
| **ХӨТӨЛБӨР YII**<br>**“Худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх замаар менежментийг сайжруулах, худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг хөгжүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 7.1.37.**<br>“Цахим дэлгүүр”, “Цахим каталоги”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх | - Цахим дэлгүүрээр нийлүүлэгдэх бараа, ажил, үйлчилгээний цахим каталогийг бий болгох,<br>- Системийн хэрэглэгчид чадавхижсан байх,<br>- II – IY улиралд. | Төсвийн байгууллагууд урсгал зардлаар худалдан авдаг зарим барааг цахим дэлгүүрээр худалдан авна. | МТИХ, ХААЗБХ, ТСХ | Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан 101 бараанаас шилж каталог үүсгэх, Аж үйлдвэрийн яамтай хамтарсан өдөрлөг зохион байгуулах талаар харилцан тохиролцсон. Стандартчилал, хэмжил зүйн газраас Тохирлын баталгаанд хамрагдаж бүтээгдэхүүн үйлчилгээ нь стандартын шаардлага хангаж гэрчилгээжсэн байгууллагуудын жагсаалтыг тус байгууллагад ирүүлснийг хүлээн авч, худалдан авах ажиллагааны явцад дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, худалдан авах ажиллагаанд шаардлагатай цахим каталогийг үүсгэхэд ашиглаж байна. (ХШ-50%) |
| **Арга хэмжээ 7.2.38**<br>Худалдан авах ажиллагааны гэрээний цахим мэдээллийн сан үүсгэх, “Цахим гэрээ”-ний системийг хэрэглээнд нэвтрүүлэх | - Систем хэрэглээнд нэвтэрсэн байх,<br>- Худалдан авах ажиллагааны гэрээний цахим мэдээллийн сан үүссэн байх,<br>- Жилдээ. | Төсвийн байгууллагууд тендер шалгаруулалт зохион байгуулж, тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний цахим сан үүсч, гэрээний талаарх мэдээллийн ил тод байдал хангагдсан байна. | МТИХ, ХХХэлтэс | “Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” төслийн нэг дэд систем болох “Цахим гэрээ” буюу “Гэрээний удирдлагын систем”-ийн тухайд хөгжүүлэлтийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд одоогоор гэрээг сканердаад хавсаргаж оруулах нөхцөл буюу уламжлалт тендер шалгаруулалтын хэсэг бүрэн дууссан бол цахимаар байгуулагдах гэрээний хувьд “Цахим гарын үсэг” хэрэглээнд нэвтрэхээс хамаарч гарах өөрчлөлтийн дараа ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна. (ХШ-70%) |
| **Арга хэмжээ 7.3.39.**<br>“Цахим тайлан”-гийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх | - Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, явц, үр дүн, хэрэгжилтийн тайлан цахим | Худалдан авах ажиллагааны талаарх статистик тайлан, мэдээг тухайн өдрийн | МТИХ, ТСХ, ХААЗБХ | Худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн цахим тайлангийн системийг боловсруулж ашиглахад бэлэн болгосон. Үүнд, Сангийн сайдын 2012 оны 12 сарын 13-ний өдрийн 264 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэлбэрээр гардаг болсон байх,<br>- Жилдээ. | байдлаар системээс боловсруулан гаргах боломжтой болсон байна. | | журам"-д заасны дагуу бүх төсвийн ерөнхийлөн захирагчийн болон захиалагч байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн тайлан, худалдан авах ажиллагааны тайланг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр захиалагч байгууллагуудын худалдан авах ажиллагааны явцыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэх боломжийг болов.<br>Цахим тайлангийн дэд системийн гол давуу тал нь хэрэглэгч өөрийн тайлангийн загварыг динамик байдлаар системд үүсгэж тухайн загварын дагуу өөрт шаардлагатай тоон мэдээллийг гарган авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд эхний байдлаар тайлангийн загваруудыг системд оруулсан. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 7.4.40.** Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх | - Системийг нэвтрүүлэх,<br>- Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн цахим мэдээллийн санг бий болгох,<br>- Жилдээ. | Төсвийн байгууллагуудын тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөний цахим мэдээллийн сан бий болсон байна. | МТИХ, ТСХ, ХААЗБХ | Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн төлөвлөлтийн системд захиалагч байгууллагуудын 2012, 2013, 2014, 2015 оны нийт төлөвлөгөөг өгөгдөл хөрвүүлэлтээр оруулсан бөгөөд 2016 оны 750 захиалагч байгууллагын нийт 5443 төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг системд оруулсан. Лавлах мэдээлэлд 10114 бараа, ажил үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан бөгөөд дэлгэрэнгүй төлөвлөгөөг үүсгэхэд шаардлагатай барааны каталог болох UNSPSC олон улсын стандарт кодлолоор шинэ систем рүү хөрвүүлэлт хийж, ХААГ-ын дэлгэрэнгүй төлөвлөгөөг үүсгээд байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 7.5.41.** "Ухаалаг тендер" гар утсанд суурилсан программыг хэрэглээнд нэвтрүүлэх | - Программ хангамжийг ашиглалтад оруулсан байх,<br>- Жилдээ. | Иргэд өөрийн гар утаснаас тендертэй холбоотой мэдээллийг авдаг, санал, хүсэлтээ илэрхийлдэг болсон байна. | МТИХ | Цахим худалдан авах ажиллагааны "Ухаалаг тендер" гар утсанд суурилсан программ гар утасны Андройд болон IOS үйлдлийн систем дээр дата төвөөс интернет сүлжээнд ажиллаж байгаа бөгөөд дизайн сайжруулалтын ажил хийгдэж байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 7.6.42.** "Мэдээлэл солилцоо" дэд системийг худалдан авах үйл ажиллагаанд нэвтрүүлэх | - Системийг нэвтрүүлж, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог шуурхай болгох, | Тендерийн үнэлгээг цахим мэдээлэлд үндэслэн магадалж, төрийн байгууллагуудын | МТИХ, ХААЗБХ | "Цахим худалдан авах ажиллагааны II үе шат" хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд гүйцэтгэж байгаа цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн "Мэдээлэл солилцоо" дэд системээр Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас Үндэсний Дата төвөөр дамжуулан УБСЕГ-ын Мэдээллийн нэгдсэн сангаас хуулийн этгээдийн талаарх мэдээллийг солилцох тухай № 14/30 тоот гэрээ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Тендерийн үнэлгээг цахим мэдээлэлд үндэслэн магадлах боломжийг бий болгох,<br>- Жилдээ. | уялдаа холбоог сайжруулсан байна. | | байгуулан ажиллаж байна.<br>Сангийн яамны “Санхүүгийн тайлангийн е-баланс“ системээс хуулийн этгээдийн борлуулалтын орлого, түргэн хөрвөх чадвар, санхүүгийн тайлан зэргийн талаарх мэдээллүүдийг солилцож байна.<br>Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн “Мэдээлэл солилцоо” дэд системийг Гааль, татварын ерөнхий газрын системийн хуулийн этгээдийн мэдээллийн санд бүртгэгдсэн хэрэглэгчийн нэр, хувийн түлхүүрээ ашиглан ЦХАА-ны системд нэвтрэх боломжтой болгож, хуулийн этгээдийн татварын үлдэгдэл болон үйл ажиллагааны борлуулалтын орлого, автомашины лавлагааг авах талаарх мэдээллийг цахим хэлбэрээр солилцож байна.<br>“Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох гэрээ”-г ХААГ-ын 1/88 тоот албан бичгээр 2016-03-10-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газарт, “Татвар төлөгчдийн мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох гэрээ”-г ХААГ-ын 1/89 тоот албан бичгээр 2016-03-10-ны өдөр Гааль, татварын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн боловч одоогоор албажаагүй, хүлээгдэж байна.<br>Мөн Зам, тээврийн яамтай цахим тендерт оролцогч хуулийн этгээдийн машин механизмын бүртгэлийн талаарх мэдээлэл сорилцох хүсэлтийг 2016-06-10-ны өдрийн 1/735 тоот албан бичгээр хүргүүлээд байна. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 7.7.43.** Худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, байгууллагын вэб хуудасны график, дизайныг боловсруулах | - Цахим систем болон вэб хуудасны хэрэглэгчийн интерфэйс хялбар, ойлгомжтой болсон байх,<br>- Жилдээ. | Худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, байгууллагын вэб хуудасны график, дизайн боловсруулагд-сан байна. Хэрэглэгчид мэдээлэл авахад хялбар болж, мэдээллийн шуурхай байдал хангагдана. | МТИХ | “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн II үе шат” хөрөнгө оруулалтын төслөөр гүйцэтгэж байгаа нэгдсэн системийн хөгжүүлэлтийг “Интерактив” ХХК хийж байгаа бөгөөд системд нэмэх, дизайн, хэрэглээг хялбарчлах арга замыг олж нэвтрүүлэх, засварлах, сайжруулах зүйлсийг хамтран гаргаж тухай бүрд хөгжүүлэн сайжруулж байна. Мөн “Интерактив” ХХК –аас томилогдсон ажлын хэсэгтэй хамтран системийн тестийн ажлыг байнга туршиж ажилласан.<br>Худалдан авах ажиллагааны газрын www.e-tender.mn цахим хуудсанд нийтэлж олон нийтийн хүртээл болгох шаардлагатай мэдээ, мэдээллийг шаардлагатай үед шуурхай зохион байгуулалт, техникийн гүйцэтгэлийг хангаж ажилласан. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 7.8.44.** Худалдан авах | - Худалдан авах ажиллагааны | Худалдан авах ажиллагааны | МТИХ | “Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд гүйцэтгэж багйаа нэгдсэн системийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ажиллагааны нэгдсэн системийн эх кодыг судалж, цаашдын хөгжүүлэлтийг хийх | нэгдсэн системийн эх кодыг судлах,<br>- Цахим системийн хөгжүүлэлтийг хийх<br>- Жилдээ. | системийн үйл ажиллагаа, хэрэглээг сайжруулж, шаардлагатай хөгжүүлэлтийг хийсэн байна. | | шаардлагууд, диаграммууд болон өгөгдлийн архитектурыг судалсан бөгөөд “Интерактив” ХХК-ийн төслийн баг системийн хөгжүүлэлтийг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсний дараа системийн кодчилол болон өгөгдлийн баазыг нарийвчлан судлахаар төлөвлөж байна. (ХШ-50%) |
| **Арга хэмжээ 7.9.45.** Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийн бүртгэл, ангиллын мэдээллийн сан бүрдүүлж хөтлөх, нэгдсэн тоо баримт болон бусад мэдээллийг бэлтгэх | - Бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бий болгох,<br>- Хэрэглэгчийг мэдээллээр хангах,<br>- Жилдээ. | ААН-ийн талаарх тодорхой судалгаа, мэдээлэлтэй болно. | ХААЗБХ | Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийн бүртгэл, ангиллын мэдээллийн сан бүрдүүлэн хөтөлж, нэгдсэн тоо баримт болон мэдээллийн санг бий болгов. Уг санд 4150 ААН-ийн мэдээлэл үүссэн. Уг мэдээллийн сангаас хэрэглэгчдийг мэдээллээр ханган ажиллаж байна. (Б-100%) |
| **Дөрөв. “Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг дээшлүүлэх”** гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: | | | | |
| **ХӨТӨЛБӨР ҮIII**<br>**“Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, төрийн байгууллагуудын урсгал зардлын хэмнэлт бий болгох”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 8.1.46.** Төсвийн байгууллагын урсгал зардлаар санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг тодорхойлох судалгааг шинэчлэх | - Ерөнхий гэрээгээр нийлүүлэгдэх 5 хүртэлх барааны зах зээлийн судалгааг хийх,<br>- Судалгаа хийх зардлын тооцоог хийж, шийдвэрлүүлэх,<br>- Жилдээ. | Холбогдох судалгаа шинэчлэгдэн 2017 онд зохион байгуулах Ерөнхий гэрээгээр гүйцэтгэх барааны нэр төрөл тодорхой болно. | ТСХ | Худалдан авах ажиллагааны газраас 2017 оны "Ерөнхий гэрээ"-ний худалдан авалтын жагсаалтад 2016 онд Ерөнхий гэрээгээр хэрэгжүүлэх 4 төрлийн барааны худалдан авалтаас гадна "Албан маягт, дугтуй", "Ариун цэврийн цаас", "Цэвэр ус", "Эм, эмийн хэрэгсэл", "Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл" зэрэг 5 төрлийн шинэ бараа, бүтээгдэхүүнийг Ерөнхий гэрээгээр худалдан авах саналыг боловсруулж удирдлагын түвшинд шийдээд байна. Уг бараа, бүтээгдэхүүний зах зээлийн буюу эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийхээр бэлтгэж байна. (ХШ-50%) |
| **Арга хэмжээ 8.2.47.** Худалдан авах ажиллагааны төлөвлөлттэй холбоотой тулгамдсан асуудлыг тодорхойлох | - Албан хаагчдын дунд уулзалт-ярилцлага зохион байгуулах,<br>- Тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга хэмжээг авах.<br>- II улиралд. | Тулгамдсан асуудал тодорхой хэмжээнд буюу бүрэн шийдвэрлэгдсэн байна. | ТСХ | Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд төлөвлөлттэй холбоотой тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулах хугацааг хойшлуулсан. Хэрэгжих хугацаа болоогүй байна. (ХБ.) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Арга хэмжээ 8.3.48.** Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан тендер шалгаруулалтын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээлэл - судалгааг авч, нэгтгэн дүгнэх | - Судалгаа мэдээллийг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нараас авч нэгтгэх,<br>- Нэгдсэн дүнг гаргаж, дүгнэлт хийх,<br>- III улиралд. | Тендер шалгаруулалтын талаарх харьцуулсан судалгаа хийж, дүгнэсэн байна. | ТСХ | Төлөвлөсөн хугацаа болоогүй байгаа. (ХБ.) |
| **ХӨТӨЛБӨР IX**<br>**“Худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээллийн сангийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 9.1.49.** Худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнгийн талаар иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох, судалгаанд мониторинг хийх | - Судалгааны асуулга боловсруулах.<br>- Тендерт оролцогч аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, ХААГ-ын албан хаагчид болон орон нутгийн нэгжүүд, иргэдээс санал асуулга авах,<br>- Дүнг гаргаж, дүгнэлт хийх.<br>- Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байх. | Иргэд, олон нийт, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дээшилсэн байна. Гомдол багассан байна. Санал асуулгын дүнг үндэслэн авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж эхэлсэн байна. | ТСХ, ХХХэлтэс | Худалдан авах ажиллагааны чанар хүртээмж, үр дүнгийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг байгууллагын "Нэг цэг"-ийн үйлчилгээгээр дамжуулан авч эхэлсэн. Мөн 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Чингисийн талбайд болсон “Хэрэглэгчийн жил” арга хэмжээний үеэр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас судалгааг авсан. Тухайн судалгааны үр дүн, тайланг 3 дугаар улиралд нэгтгэн гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохоор төлөвлөсөн.<br>Худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал, тендер шалгаруулалт хэр шударга явагдаж байгаа талаарх иргэд, аж ахуйн нэгжээс санал асуулга авч, үр дүнг газрын удирдлагын түвшинд хэлэлцэн, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж гарган хэлтсүүдэд хүргүүлсэн. Зөвлөмжид худалдан авах ажиллагааны мэдээллийг ил тод, нээлттэй болгох, энэ талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгав.<br>Худалдан авах ажиллагааны цахим тендерийн нээлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, нээлтийн тэмдэглэл болон шалгаруулалтын үр дүнг худалдан авах ажиллагааны цахим хуудсанд цаг тухайд нь байршуулан мэдээлсэн байдалд хяналт тавин ажиллаж байна. (ХШ-50%) |
| **Арга хэмжээ 9.2.50.**<br>ХАА-ны мэргэжлийн байгууллагын 2016 онд зохион байгуулах худалдан авах | - Үнэлгээний хороо байгуулах, гишүүдийн ачааллыг тооцоход мэдээллийн технологийн | Худалдан авах ажиллагаа зохион байгуулах бэлтгэл хангагдсан байна. Мэргэжлийн холбоод, хувийн | ХХХэлтэс | Худалдан авах ажиллагааны газраас 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4-д заасны дагуу ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын хүсэлтийг хүлээн авах тухай зарыг, хамтран |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ажиллагаанд салбарын яам, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах | дэвшлийг нэвтрүүлсэн байх,<br>- Үнэлгээний хороодод 2-оос доошгүй мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх,<br>- Хамтран ажиллах гэрээ байгуулах,<br>- Мэдээллийн санг бий болгох,<br>- Хариуцлагын тогтолцоог тодорхой болгох арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавих,<br>- Жилдээ. | хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийн ажиллах нөхцөл бүрдсэн байна. | | ажиллах гэрээ, төрийн бус байгууллагын төлөөллийн анкетын хамт 2015.12.15, 2016.01.12-нд нийтдээ 2 удаа Худалдан авах ажиллагааны газрын www.e-tender.mn цахим хуудсанд байршуулсан.<br><br>2016 онд Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний загварыг шинэчлэн баталж, эрх үүргийн давхардлыг арилгах, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бөглүүлэх, үнэлгээний хорооны хуралдаанд 2-оос дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлөх, мөн урамшуулал олгох зэрэг заалтуудыг шинэчлэн тусгав.<br><br>Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах төрийн бус байгууллагын шинэчилсэн бүртгэлд 2016.06.21-ний өдрийн байдлаар нийт 38 төрийн бус байгууллагын 53 төлөөлөл бүртгэгдэж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж байна.<br><br>Тайлангийн хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулсан 38 төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын 53 төлөөлөл 45 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороонд санамсаргүй сонголтын аргаар сонгогдон ажиллаж байна. Хамтран ажиллах хүсэлт тавьсан төрийн бус байгууллагуудын материалыг нягталж, тухай бүр гэрээ байгуулан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилон ажиллуулж байна.<br><br>2016 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан төрийн бус байгууллагуудын гишүүдтэй 2016.04.19-ний өдөр АТГ-тай хамтран уулзалт, семенар зохион байгуулав. Уг уулзалт, семинарт 20 гаруй төрийн бус байгууллагын гишүүд болон ХХХ, ЗУХ, ХААЗБХ-ын мэргэжилтнүүд, оролцож, худалдан авах ажиллагаа зохион байгуулахад анхаарах асуудал, холбогдох хууль, тогтоомжийн талаар таниулж, үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрхэн тавих талаар сургалт, семинар өгч, авлига, ашиг сонирхлын зөрчил, худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаар судалгаа авав. (Б-100%) |
| **Арга хэмжээ 9.3.51.** Худалдан авах ажиллагааны талаар иргэд, олон нийтээс гарсан санал хүсэлтийг | - Албан бичиг, цахим хуудас, санал хүсэлтийн хайрцаг болон утсаар ирүүлсэн санал, | Олон нийтийн санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэн, эргэх холбоог хангаж | Бүх хэлтэс | <u>Байгууллагын бичиг хэрэгт бүртгэгдсэн иргэний өргөдөл, гомдлын мэдээ:</u><br><br>Тайлант хугацаанд байгууллагын албан хаагчдаас болон иргэдээс нийт 18 өргөдлийг бичгээр хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариу өгч ажиллав. Ирүүлсэн өргөдөл, гомдлын 55,3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| шуурхай хүлээн авч шийдвэрлэх | хүсэлтийг бүртгэлжүүлэх,<br>- Судалж, шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах,<br>- Шийдвэрлэлтийн талаар хариу өгөх,<br>- Шийдвэрлэлтийн нэгдсэн мэдээ, тайланг нэгтгэж, олон нийтэд мэдээлэх,<br>- Жилдээ. | ажилласан байна. | | хувь нь байгууллагын албан хаагчдаас ирсэн чөлөө, буцалтгүй тусламж хүссэн өргөдөл байхад үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар ирүүлсэн өргөдөл 44,7 хувийг эзэлж байна.<br><br><u>Засгийн газрын “11-11” төв-д ирсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол:</u><br><br>Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар Засгийн газрын “11-11” төвд 11 санал, гомдол, шүүмжлэл ирснийг хүлээн авч, тухай бүр хариу өгсөн.<br><br>Иргэдээс ирсэн санал, гомдол, хүсэлтийн төрөл: санал - 6, гомдол - 3, шүүмжлэл – 1, талархал – 1, нийт санал, хүсэлтийн 10 нь дуудлагаар, 1 саналыг цахим хуудсаар ирүүлсэн байна. “11-11” төвд худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар ирсэн иргэдийн санал, гомдол, шүүмжлэлийг өнгөрсөн 2 жилийн мөн үеийн байдалтай харьцуулбал 15 хувиар буурсан байна.<br><br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, газрын даргын тушаалын жагсаалтыг улирал, хагас жилийн байдлаар гарган байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлж байна.<br><br><u>Цахим худалдан авах ажиллагааны системтэй холбоотой МТИХ, “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д утсаар, бичгээр, биечилж хандан гаргасан өргөдөл, хүсэлтийн талаар:</u><br><br>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулахаар цахим системд бүртгүүлэх захиалагч байгууллагын (давхардсан тоогоор) нийт 25 өргөдөл, хувийн нууцлалын код авах 52 өргөдлийг хүлээн авч, ажлын 3 хоногийн хугацаанд багтаан шийдвэрлэн, баталгаажуулж үйлчилсэн.<br><br>2015 оны эхний хагаст 756 удаагийн тендер шалгаруулалтад 2531 ААН байгууллага оролцсон ба цахим худалдан авах ажиллагааны талаар иргэдээс 15 санал, хүсэлт, гомдол ирснээс 5 нь гомдол байсан бол 2016 оны 06 сарын 17-ны байдлаар, 1588 удаагийн тендер шалгаруулалтад 6403 ААН байгууллага оролцож, нийт 23 санал, хүсэлт, гомдол ирсний 8 нь гомдол байна. Гомдол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.3 хувиар багассан үзүүлэлттэй байна.<br><br>“Цахим тендер шалгаруулалтын систем”-ийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтүүдийг нэгтгэн боловсруулж, “Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” хөрөнгө оруулалтын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | төслийн гүйцэтгэлд шаардлага болгон тусгаж ажилласан.<br>Цахим худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжээс шаардлагатай үед “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан ажиллаж, тендерт оролцогч дунджаар 120 аж ахуй нэгж, байгууллагын гомдол, хүсэлтэд хариу өгч, шуурхай үйлчилгээ, дэмжлэг үзүүлж ажиллав. (Б-100%) |
| **ХӨТӨЛБӨР X**<br>**“Худалдан авах ажиллагааг зохион байгуулагч болон оролцогчдын чадавхийг бэхжүүлэх”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 10.1.52.**<br>Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, “Цахим дэлгүүр”-ийн талаар олон нийтэд сурталчлан таниулах, сургалт, семинар зохион байгуулах | - Зорилтод сургалтуудын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах,<br>- Аж ахуйн нэгж, төрийн байгууллага, иргэдийн төлөөллийг хамруулах,<br>- Орон нутагт сургагч багш бэлтгэх,<br>- Жилдээ. | Цахим худалдан авалтын талаар мэдээлэл олон нийтэд хүрч, ойлголт, мэдлэг нэмэгдэж, системийн ашиглалт сайжирна. | МТИХ, ЗУХ | “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-ийг танилцуулах, сургагч багш бэлтгэх сургалтыг 2016 оны 01 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулж, орон нутгийн 31 нэгжийн 52 албан хаагчийг хамруулсан. Уг сургалтын хөтөлбөрийн хүрээнд:<br>- 2016.01.25-26-ны хооронд системийн хичээлийг лекц болон лабораторийн хэлбэрээр орсон.<br>- Цахим системийн гарын авлагыг бэлдэж ном хэлбэрээр тарааж өгсөн.<br>- Системтэй холбоотой саналуудыг бичгээр авсан.<br>Сургалтын хугацааны зургууд болон системийн гарын авлагыг CD хэлбэрээр хүн бүрд хуулж өгсөн. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 10.2.53.**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх “Суурь мэдлэг олгох” сургалтыг зохион байгуулалтаар ханган сургалтын эрх бүхий ТББ-тай хамтран ажиллаж, шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах | - Сургалтыг зохион байгуулалтаар хангах,<br>- Шалгалтыг улсын хэмжээнд 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулах,<br>- АЗ гэрчилгээ эзэмшигчдийн цахим мэдээллийн санд баяжилт хийн, ил тод мэдээлэх,<br>- АЗ гэрчилгээг ТҮЦ машинаас авдаг болох,<br>- Жилдээ. | Худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны гишүүдийн чадавхи сайжирсан байна. Шалгалтыг улсын хэмжээнд 100 хувь цахим хэлбэрээр авдаг болсон байна. | ЗУХ МТИХ | Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд Сангийн яамнаас уг сургалт явуулах эрх авсан 6 хуулийн этгээд (ХХСТ, ХААСЗӨТ, МУИС Бизнес төв, ХАААХ, ХААГ)-ийн явуулж байгаа сургалтын үр дүнг шалгах үйл ажиллагаанд ХААГ-аас чиг үүргийн дагуу оролцож, сургалтад хамрагдагсдаас шалгалт авч, гэрчилгээ олгох ажлыг тус байгууллага эрхэлж байна. Шалгалтыг цахим хэлбэрээр авах, цахим системийн сургалт зохион байгуулахад зориулан тусгай тоноглол бүхий танхим, техник хангамж, компьютерүүдийн хэвийн ажиллагааг ханган ажиллав.<br>2016 оны 06 сарын 21-ний өдрийн байдлаар нийт 199 удаагийн цахим шалгалт авсны 48 нь дахин шалгалт байна. Улаанбаатар хотод 145, орон нутагт 29 (Булган, Өмнөговь, Төв, Орхон, Завхан, Ховд, Хэнтий аймгууд, Багануур, Налайх дүүрэг), орон нутагт онлайн хэлбэрээр 25 (Шивээ-Овоо, Говь-Алтай, Сүхбаатар, Говьсүмбэр, Эрдэнэт, Баянхонгор, Дархан-Уул, Шивээ-Овоо, Дорноговь, Хөвсгөл, Багахангай) шалгалт авсан байна. Нийт 199 удаагийн шалгалтад 2865 хүн хамрагдснаас 1709 хүн шалгалтад тэнцэж, худалдан авах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ авсан.<br>Худалдан авах ажиллагааны чиглэлээр "суурь мэдлэг олгох" сургалтад хамрагдан шаардлагатай мэдлэг эзэмшсэнийг гэрчлэх гэрчилгээг Төрийн үйлчилгээний цахим машинаар дамжуулан олгох тухай саналыг 2015 онд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газарт албан бичгээр хүргүүлж байсан нь шийдвэрлэгдэж, "Төрийн үйлчилгээний цахим системийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 254 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 11-т ТҮЦ машинаас олгох үйлчилгээний жагсаалтад уг гэрчилгээг олгох асуудал тусгагдсан байна. Тиймээс тус байгууллагаас олгож байгаа гэрчилгээг Төрийн үйлчилгээний цахим систем болон Төрийн үйлчилгээний цахим машинаар авах боломжтой болсон. (Б-100%) |
| **Арга хэмжээ 10.3.54.** Худалдан авах ажиллагаанд оролцогч ААН-тэй хамтарсан сургалт, семинар, зохион байгуулах | - Сургалт, семинарын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах,<br>- Худалдан авах ажиллагаатай холбоотой ерөнхий заавар, аргачлал, гарын авлага бүхий мэдээллийг бэлтгэх,<br>- Улирал бүр. | Худалдан авах ажиллагаанд тулгамдсан асуудал шийдвэрлэгдэнэ. Худалдан авах ажиллагаанд оролцогч ААН-ийн чадавхи нэмэгдсэн байна. | ЗУХ, ХХХэлтэс ХААЗБХ МТИХ | Тендерт оролцогч аж ахуй нэгж, байгууллагуудын холбогдох албан хаагч, төлөөллийг чадавхжуулахад зориулсан цахим худалдан авах ажиллагааны систем www.meps.gov.mn–ийн сургалтыг 2016 оны 03 сарын 04-ний өдрөөс 2016 оны 06 сарын 17-ны өдөр хүртэл долоо хоног бүрийн Пүрэв гаригт 10:00 цагаас тогтмол зохион байгуулж, 28 удаагийн сургалтад аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор нийт 123 төлөөллийг хамруулсан байна. Энэ тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76 хувиар буурсан нь тендерт оролцогч хуулийн этгээдийн цахим тендерт оролцох чадамж дээшилснийг харуулж байна. (2015 онд 30 удаагийн сургалтад 513 ААН-ийн төлөөлөл хамрагдаж байсан)<br>Цахим худалдан авах ажиллагааны www.meps.gov.mn системийн гадаадын этгээдүүдэд зориулсан ерөнхий мэдээлэл бүхий заавар, зөвлөмжийн эхийг МТИХ-ээс бэлтгэж англи хэлээр хөрвүүлэн цахим системд байршуулсан.<br>Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба, Эрүүл мэнд, спортын яамтай хамтран Монгол Улсад Хэрэглэгчийн байгууллага үүссэний 25 жил, Олон улсын хэрэглэгчийн өдрийг тохиолдуулан нээлттэй өдөрлөгийн арга хэмжээг 2016 оны 03 сарын 15-ны өдөр Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 6 агентлаг, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоотой хамтран Чингисийн талбайд зохион байгуулсан. Нээлттэй өдөрлөгийн үеэр Худалдан авах ажиллагааны газраас иргэд, хэрэглэгчдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад 50 хувийн хөнгөлөлттэй үнээр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | бүртгэх, аж ахуйн нэгжүүдэд нууцлалын код өгөх, түүнчлэн 2015 онд Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан тендер шалгаруулалтад амжилттай оролцож шалгарсан дотоодын үйлдвэрлэгчдийн төлөөлөл болох “Дархан нэхий” ХХК, “Амно” ХХК, “Зорбион” ХХК өөрсдийн үйлдвэрлэж нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнээ сурталчлах ажлыг зохион байгуулав. Мөн энэ үеэр Худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнгийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг 50 гаруй иргэнээс авч, судалгааны дүнгийн дагуу иргэдэд чиглэсэн тодорхой ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br><br>Монгол Улсын Сангийн яам, Азийн хөгжлийн банкны “Тогтвортой хөгжлийг дэмжих төсөл”-ийн нэгжтэй хамтран “Худалдан авах ажиллагааны Удирдах ажилтнуудын улсын зөвлөгөөн”-ийг 2016 оны 04 сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус зөвлөгөөний талаар 20 минутын нэвтрүүлгийг Азийн хөгжлийн банкны төслийн нэгжтэй хамтран бэлтгэж, МҮОНТ-ээр гарган олон нийтийн хүртээл болгов.<br><br>Өмнөговь аймгийн ЗДТГазар, тус аймгийн ХАААлбатай хамтран “Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдын анхдугаар уулзалт-семинар”-ыг 2016 оны 05 сарын 03-06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад хотод зохион байгуулсан. (Б-100%) |
| **Арга хэмжээ 10.4.55.** Худалдан авах ажиллагааг зохион байгуулагч болон оролцогчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чадавхижуулах | - Хууль, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангаж, хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, албан бичиг, хүсэлтэд хариу өгөх,<br>- Яриа таниулга хийх,<br>- Газрын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр эрх зүйн мэдлэг мэдээлэл олгох.<br>- Жилдээ. | Худалдан авах ажиллагааг зохион байгуулагч болон захиалагч нар хууль, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангагдсан, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | ХХХэлтэс | 2016 оны 01 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт”-ад Хууль зүйн яам, БСШУЯ, Гадаадын иргэн харьяат, шилжилт хөдөлгөөний газар, Баянгол дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Зам тээврийн хөгжлийн төвийн нийт 42 албан хаагчийг хамруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, эрх зүй, худалдан авах ажиллагааны суурь мэдлэгийг олгож, чадавхижуулав. Мөн 2016 оны 05 дугаар сарын 03-05-ны хооронд Өмнөговь аймагт болсон худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдын анхдугаар уулзалтын үеэр “Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт”-ыг зохион байгуулж, орон нутгийн төрийн болон ТББ, ААН-ийн 106 төлөөллийг хамруулан хууль эрх зүйн болон худалдан авах ажиллагааны мэдлэгийг дээшлүүлэв.<br><br>Захиалагч болон тендерт оролцогчдод худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн талаар 164 удаа утсаар болон биечлэн уулзаж зөвлөгөө, мэдээлэл өгч, бичгээр ирүүлсэн 12 хүсэлт, тодруулгад |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | тухай бүр хуулийн хугацаанд хариу хүргүүлэн захиалагч болон тендерт оролцогчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна.<br><br>2016 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан төрийн бус байгууллагуудын гишүүдтэй 2016.04.19-ний өдөр АТГ-тай хамтран уулзалт, семинар зохион байгуулав. Уг уулзалт, семинарт 20 гаруй төрийн бус байгууллагын гишүүд болон ХХХ, ЗУХ, ХААЗБХ-ын мэргэжилтнүүд, оролцож, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад анхаарах асуудал, холбогдох хууль, тогтоомжийн талаар таниулж, үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрхэн тавих талаар сургалт, семинар өгч, авлига, ашиг сонирхлын зөрчил, худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаар судалгааг авав. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 10.5.56.** Худалдан авах ажиллагааны салбарын нэгдсэн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах | - Хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах,<br>- Санхүүжилт, зардлын асуудлыг шийдвэрлүүлэх,<br>- Хэлэлцэх асуудлуудыг тодорхойлох,<br>- Y сард зохион байгуулах. | Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам тодорхой болно. | ХААЗБХ, Бусад хэлтэс | “Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдын анхдугаар уулзалт-семинар”-ыг Монгол Улсын Сангийн яам, Шадар сайдын Ажлын алба, Авлигатай тэмцэх газар, Өмнөговь аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Өмнөговь аймгийн Худалдан авах ажиллагааны алба зэрэг байгууллагатай хамтран 2016 оны 05 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад хотод зохион байгуулав. Уг уулзалт-семинарт 11 аймаг, 7 дүүргийн худалдан авах ажиллагааны салбарын 90 гаруй албан хаагчдыг хамруулж, холбогдох илтгэлүүдийг хэлэлцүүлэн, туршлага солилцож, салбарын албан хаагчид болон тендерт оролцогч ААН-ийн төлөөллийг чадавхижуулах, тэдний мэдлэг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтуудыг зохион байгуулав.<br><br>Дэлхийн банкны санхүүжилтээр “Худалдан авах үйл ажиллагаанд оролцогчдыг чадавхижуулах” сургалтыг зохион байгуулахаар бэлтгэж байгаа бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд удирдамж, төсвийн төслийг боловсруулан Дэлхийн банкинд хүргүүлж, төсвийг батлуулаад байна. Сургалтыг салбарын албан хаагчид, худалдан авах ажиллагаанд оролцогчид гэх мэт зорилтод бүлгүүдэд чиглүүлэн төрөлжүүлж, оны сүүлийн хагас жилд зохион байгуулна. (Б-100%) |
| **Тав. “Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах”** гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: | | | | |
| **ХӨТӨЛБӨР XI**<br>**“Орон нутгийн нэгжийг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалтаар хангах”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Арга хэмжээ 11.1.57.** “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-ийг танилцуулах, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах чадавхийг сайжруулах | - Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах,<br>- Аймаг бүрт цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулах.<br>- Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчид, төрийн байгууллага, ААН-ийн төлөөллийг оролцуулах,<br>- I, II, III-р улиралд. | Захиалагч байгууллагууд болон тендерт оролцогчид цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг ашиглах чадвартай болсон байна. | ЗУХ МТИХ | “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-ийг танилцуулах, сургагч багш бэлтгэх сургалтыг 2016 оны 01 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулж, орон нутгийн 31 нэгжийн 52 албан хаагчийг хамруулсан.<br><br>2016 оны сүүлийн хагас жилд Дэлхийн банкны санхүүжилтээр орон нутагт чадавхи сайжруулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн удирдамж, төсвийн төслийг боловсруулан Дэлхийн банкинд хүргүүлж, батлуулаад байна.<br><br>"Цахим худалдан авах ажиллагааны II үе шат" хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлийн хүрээнд яам, агентлагийн холбогдох 43 албан хаагчдыг хамруулан танилцуулга - сургалтыг 2016-02-24-нд зохион байгуулж, санал солилцлоо. Сургалтын үеэр хэрэглэгдэх гарын авлага, сургалтын материалыг бэлтгэж тараав. (ХШ-90%) |
| **Арга хэмжээ 11.2.58.** Орон нутгийн иргэдэд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг хэрэгжүүлэх “Сууръ мэдлэг олгох” сургалт зохион байгуулах | - Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах,<br>- Захиалагчийн төлөөлөл, төрийн бус байгууллагын гишүүн, иргэдийн төлөөллийг хамруулах,<br>- Жилдээ. | Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох захиалагчийн төлөөлөл, төрийн бус байгууллагын гишүүн, иргэдийн чадавхи сайжирсан байна. 10-аас дээш аймагт 50-аас доошгүй иргэн А3 гэрчилгээтэй болсон байна. | ЗУХ | Худалдан авах ажиллагааны газар нь Өмнөговь аймгийн Худалдан авах ажиллагааны албатай хамтран тус аймгийн сумдын төрийн байгууллагын албан хаагчид, иргэдийн төлөөллийг хамруулсан үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулж, 89 хүний худалдан авах ажиллагаанд оролцох чадавхийг дээшлүүлэн шалгалтад хамруулсан бөгөөд тэдгээрээс 40 нь худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээтэй болсон.<br><br>Бусад аймгуудад 2016 оны сүүлийн хагас жилд холбогдох сургалтыг зохион байгуулагдахаар төлөвлөсөн тул хүлээгдэж байна.<br><br>Мөн орон нутгийн Худалдан авах ажиллагааны албадын албан хаагчдын худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээний хүчинтэй хугацааны талаарх судалгааг хийв. Уг судалгаанд 17 нэгжийн 70 албан хаагч хамрагдсанаас 2016 онд 28 албан хаагч, 2017 онд 15 албан хаагч, 2018 онд 18 албан хаагч, 2019 онд 7 албан хаагчийн гэрчилгээний хугацаа дуусахаар байгаа дүн гарсантай холбогдуулан 2016 онд хугацаа дуусах Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Увс аймгийн 15 албан хаагчид уг гэрчилгээг шинэчлэн олгосон. (Б-100%) |
| **Арга хэмжээ 11.3.59.** Холбогдох хуулийг хэрэгжүүлэх, цахим худалдан авах ажиллагаа зохион | - Зөвлөгөө, арга зүйгээр хангах чиглэлийг тодорхойлсон байна.<br>- Гарын авлага | Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүд нэгдсэн ойлголтод хүрсэн | ЗУХ, МТИХ, ХХХэлтэс | Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Худалдан авах ажиллагааны газар, Өмнөговь аймгийн Засаг дарга, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны албатай хамтран 2016 оны 05 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад хотод зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдын анхдугаар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| байгуулах, үр дүнг тооцох, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах асуудлаар орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжид зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах | боловсруулж, заавар, зөвлөгөө, зөвлөмжийг тухай бүр өгч ажиллах,<br>- Тодорхой удирдамжийн дагуу орон нутагт ажиллах,<br>- Жилдээ. | байна.<br>Энэ талаар гарын авлага боловсруулж, орон нутгийн нэгжүүдэд хүргүүлсэн байна. | | уулзалт"-д оролцсон 11 аймаг, 7 дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын 90 гаруй албан хаагчдад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ж.Сарангэрэл, Г.Баярцэцэг нар "Тендер шалгаруулалттай холбоотой хяналт шалгалт, түүний мөрөөр авсан арга хэмжээ, цаашид анхаарах асуудал" сэдвийн хүрээнд онлайн сургалт хийж, авлигын эсрэг хууль тогтоомжийг орон нутгийн худалдан авах ажиллагаанд хэрэгжүүлэх, анхаарах асуудлаар мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөв.<br>Мөн худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг таниулах, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар тус аймгийн сумдын төрийн албан хаагчид, иргэдийн төлөөллийг хамруулсан үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулж, 89 хүний худалдан авах ажиллагаанд оролцох чадавхийг дээшлүүлэв.<br>Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдэд давхардсан тоогоор 31 удаа худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн талаар зөвлөгөө, мэдээллийг өгсөн. Мөн Дундговь, Өвөрхангай аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжтой холбоотой тодруулга, лавлагаа хүссэн албан бичигт тус тус хууль, эрх зүйн үүднээс хариу хүргүүлж, дэмжлэг үзүүлсэн. (Б-100%) |
| **Арга хэмжээ 11.4.60.** Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийг нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих | - Орон нутгийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих,<br>- Зөвлөмж боловсруулан, хэрэгжилтийг хангуулах,<br>- Жилдээ. | Орон нутгийн нэгжийн үйл ажиллагаа нэгдсэн удирдлагаар хангагдсан байна. Зөвлөгөө, зөвлөмж хүргүүлсэн байна. | ХХХэлтэс, ЗУХ | Шадар сайд, аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнд "Худалдан авах ажиллагааны албыг цахим хэлбэрээр тендер зарлах боломж бүрдүүлэхэд Засаг даргын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах тухай" тусгуулан, орон нутгийн нэгжүүдэд 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 80 хүртэлх хувийг цахимаар зохион байгуулах тухай ХААГ-ын даргын албан бичгийг тус тус хүргүүлэв.<br>Цахим тендерт оролцогчдын хураамжийн нэхэмжлэхийг 2016 оны 01 дүгээр улирлын байдлаар орон нутгийн ХААА-аас ирүүлэх талаар 31 нэгжид мэдэгдэж ажилласнаар 16 нэгжээс 89,6 сая төгрөгийг нэхэмжлээд байгаа бөгөөд тэдгээрийг цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн дансанд төвлөрсөн орлогоос тухайн орон нутгийн нэгжийн дансанд шилжүүлэх ажлыг МТИХ, санхүүгийн ажилтнаар хянуулан шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллав.<br>"Дотоодын давуу эрх тооцох тухай" Сангийн яамнаас ирүүлсэн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | чиглэлийг орон нутгийн худалдан авах ажиллагааны 31 нэгжид хүргүүлсэн.<br><br>2016 онд Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж буй орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг тус бүрээр гарган, худалдан авалтын явцын мэдээг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар гарган 21 аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, 21 аймгийн Засаг дарга, Худалдан авах ажиллагааны албадад тус тус хүргүүлэхээр бэлтгэж, албан бичгийн төслийн хамт ХААГ-ын даргад танилцуулсан. Дээд шатны болон орон нутгийн удирдлагаас хяналт тавих боломжийг бүрдүүлж, мэдээллээр хангах зорилгоор уг мэдээллийг 2016 оны эхний хагас жилийн дүнгээр гарган хүргүүлэхээр бэлтгэж байна. (Б-100%) |
| **“Зургаа. Байгууллагын дотоод зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэх”** чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ: | | | | |
| **ХӨТӨЛБӨР XII**<br>**“Байгууллагын бүтцийн нэгжүүдийн уялдаа холбоог сайжруулан, байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах”** хөтөлбөрийн хүрээнд: | | | | |
| **Арга хэмжээ 12.1.61.** Байгууллагын албан хаагчдад эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хууль, эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтийн талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмж, чиглэлээр хангах | - Холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрхэн хэрэглэх зөвлөмжийг тухай бүр албан хаагчдад хүргүүлэх,<br>- Худалдан авах ажиллагааны талаарх шинэчлэгдэж буй дүрэм, журам, зааврыг тухай бүр байгууллагын дотоод сүлжээгээр болон бусад арга хэлбэрээр нийт албан хаагчдад сурталчлан таниулах,<br>- Жилдээ. | Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэх талаар нэгдсэн ойлголттой болсон байна. Шинэчлэгдэж буй дүрэм, журам, заавартай нийт албан хаагчид шуурхай танилцаж, мэдлэг, мэдээлэл нь дээшилсэн байна. | ХХХэлтэс, ЗУХ | Тайлангийн хугацаанд, байгууллагын хуулийн асуудал хариуцсан нэгжээс тендерийн баримт бичиг, урилга 25, үнэлгээний хорооны тайлан, зөвлөмж, мэдэгдэл 27, тендерийн баталгаа чөлөөлөх тухай 14, албан бичгийн төсөл 90, тушаалын 53 төслийг тус тус хууль зүйн талаас хянаж газрын дарга болон мэргэжилтнүүдэд хууль, эрх зүйн дэмжлэг тогтмол үзүүлэн ажиллав. Мөн Сонгуулийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуульд заасан төрийн албан хаагчтай холбоотой асуудлаарх хууль, тогтоомжийн танилцуулгыг бэлтгэж, байгууллагын дотоод сүлжээний www.able.mn цахим хуудсанд байршуулан, нийт албан хаагчдад хүргэж танилцуулсан.<br><br>Үнэлгээний хорооны үйл ажиллагаа худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хүрээнд явагдсан эсэхэд хяналт тавих, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.2-т заасан захиалагчийн эрх үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Захиалагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай” 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/57 дугаар тушаал гарган Хууль, хяналтын хэлтсээс тайлан, мэдэгдэл хуульд нийцэж байгаа байдалд хяналт тавьж, 19 төсөл, арга хэмжээний 45 багц ажилд холбогдох илтгэх хуудас бичиж, удирдлагад танилцуулан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллав.<br><br>Холбогдох хууль, тогтоомжид орсон өөрчлөлт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус байгууллагад ирүүлж байгаа Засгийн газраас шинээр батлагдсан шийдвэр, байгууллагын дотоодод мөрдөх журам, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | дүрэм, заавар, аргачлал, холбогдох байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг тухай бүр байгууллагын дотоод сүлжээний холбогдох цэсүүдэд байршуулан байгууллагын албан хаагчдыг мэдээллээр шуурхай ханган ажиллаж хэвшсэн.<br>Мөн байгууллагын www.e-tender.mn цахим хуудсанд олон нийтэд мэдээлвэл зохих хууль, тогтоомж, журам, зааврыг байршуулан ил тод мэдээлж байна. (Б-100%) |
| **Арга хэмжээ 12.2.62.** Байгууллагын архивын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангах | - Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн баталж, мөрдүүлэх,<br>- Албан хаагчдад үүссэн архивын баримт материалыг хүлээн авах, I улиралд,<br>- Албан хаагчдыг зөвлөгөө, мэдээллээр хангах,<br>- Тендер шалгаруулалтын ажил дуусч, гэрээ байгуулагдсан ажлын материалыг тухай бүр бүртгэлд хамруулан хүлээн авах,<br>- Архивын хадгаламжийн нэгжийн хадгалалт, хамгаалалтын горимыг сахих,<br>- Жилдээ. | Байгууллагын архивын бүрдүүлэлт, бүртгэл, данс бүрэн хөтлөгдөж, архивын нэгжийн баяжилт хийгдсэн байна. | ЗУХ | Байгууллагын хэмжээнд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна. 2016 он гарсаар нийт 165 байнга хадгалах, 26 түр хадгалах хадгаламжийн нэгжийг архивт шинээр хүлээн авч, данс бүртгэлд хамруулав. Үүнд:<br>- 15 гэрээний 45 байнга хадгалах, 26 түр хадгалах хадгаламжийн нэгж,<br>- Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу нийт 120 хадгаламжийн нэгж.<br>2012 оноос 2014 оныг хүртэлх 25 архивын бүртгэлийг нэгтгэж байгууллагын хөтлөх хэргийн жагсаалтын дагуу ангилан, дэс дараалллыг өөрчлөх ажил хийгдсэн.<br>Байгууллагын архивын үйл ажиллагааны журам, заавар, стандартыг хангах хүрээнд дараах нэг бүрчилсэн ажилбарууд хийгдсэнийг тоо баримтаар дурдвал:<br>- 175 хадгаламжийн нэгжийг үдэж хавтасласан байна. (Давхардсан тоогоор болон санхүүгийн баримт шүүх рүү явуулж байгаа хуулбар хувь гэх мэт)<br>- 100 ширхэг хавтас зүссэн.<br>- Шүүх, ААН болон яамдаас ирсэн албан бичиг, хүсэлтийн дагуу 1821 хуудас архивын материалыг хуулбарлан "Хуулбар үнэн" дардсаар баталгаажуулан явуулсан.<br>- Байнга болон түр хадгалах 82 хадгаламжийн нэгжийг албан хаагчдын ажлын хэрэгцээнд ашиглалтад бүртгэлээр гаргасан.<br>- Нээлт хийсэн 29 тендерийн баримт бичгийн эх хувийг лацдахад бэлдэж цоолсон.<br>Цахим архив үүсгэх ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор програм хангамж, тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгийн талаар ХААГ-ын 2016 оны төсвийн төсөөлөлд санал оруулав. (ХШ-90%) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Арга хэмжээ 12.3.63.** Албан хэрэг хөтлөлтийг заавар, журмын дагуу хөтөлж, стандартыг мөрдөх | - Монгол хэлний тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартыг хангаж ажиллах,<br>- Бичиг хэргийн эргэлтийн мэдээ, тайланг гаргаж, байгууллагын тайлан, мэдээнд тусгах, хагас, бүтэн жилд,<br>- Албан хаагчдыг зөвлөгөө, мэдээллээр хангах,<br>- Жилдээ. | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандарт хангагдсан байна. | ЗУХ | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах ажлыг зохион байгуулж, албан хэрэг хөтлөлт, ирсэн бичгийг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн сан үүсгэж байна.<br><br>Байгууллагад ирсэн бичиг, өргөдлийг цахимжуулснаар дараах үр дүн гарсан. Үүнд:<br>✓ Ирсэн албан бичиг эх хувиараа, бүрэн бүтэн хадгалагдах,<br>✓ Мэдээллийн сан үүсэх,<br>✓ Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн, хяналтын карт хаагдаагүй албан бичгүүдийг нэг дороос хянах боломж нэмэгдэх,<br>✓ Ирсэн бичиг, өргөдлийн тайланг программаас нэгтгэн гаргах боломжтой болсон.<br><br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2015 онд байгууллагын бичиг хэрэгт хөтлөгдсөн 12 нэр төрлийн 34 хадгаламжийн нэгж, 1 CD-ийг архивт хүлээлгэж өгсөн.<br><br><u>Байгууллагын даргын тушаал:</u><br><br>Тайлант хугацаанд газрын даргын нийт 107 тушаал албажиж гарснаас:<br>✓ Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр (үнэлгээний хороо байгуулах болон үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай, дотоод үйл ажиллагаатай холбоотой) - 75,<br>✓ Хүний нөөцийн чиглэлээр (төрийн жинхэнэ албанд томилох, ажлаас чөлөөлөх, тэтгэлэг, чөлөө олгох тухай г.м) –32.<br><br><u>Ирсэн, явсан  бичгийн мэдээ</u>:<br><br>2016 оны эхний хагас жилд нийт 603 албан бичиг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 314 хариутай албан бичигт тухай бүр зохих журмын дагуу хариу өгч, 165 албан бичгийг холбогдох байгууллагад уламжлан, 882 албан бичиг төлөвлөн бусад байгууллагад хүргүүлсэн.<br><br>Байгууллагын бичиг хэргийн эргэлтийн мэдээг өнгөрсөн 2 жилийн хугацаатай харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа нь тус байгууллагын хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний тооноос хамаарч байгаа дүгнэлт гарч байна.<br><br>Ирсэн бичиг болон өргөдлийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээг удирдлагуудад 7 хоног бүрийн шуурхай хуралд нийт 22 удаа мэдээлэн танилцуулсан бөгөөд үүний үр дүнд ирсэн бичгийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | шийдвэрлэлт байгууллагын хэмжээнд сайжирсан. (Б-100%) |
| **Арга хэмжээ 12.4.64.** Газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, албан хаагчдад мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх | - Байгууллагын дотоод болон гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангах,<br>- Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, хэвийн ажиллагааг хангах,<br>- Жилдээ. | Байгууллагын дотоод болон гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна. | МТИХ | Байгууллагын бүтцийн нэгж болох МТИХ-ээс албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, туслалцаа, дэмжлэг үзүүлэн байгууллагын дотоод болон гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажиллав. Мөн "Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат" хөрөнгө оруулалтын төслөөр хэрэгжиж байгаа цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн гарын авлагыг www.able.mn дотоод системд байршуулсан. (Б-100%) |
| **Арга хэмжээ 12.5.65.** Албан хэрэгцээнд дотоод сүлжээний ABLE e-Office системийн хэрэглээг сайжруулж, албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх | - Удирдлагын мэдээллийн нэгдмэл байдал хангагдах нөхцөл бүрдэх,<br>- Ажлын уялдаа холбоо сайжирч, бүтээмж дээшилсэн байх,<br>- Жилдээ. | Албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэлд ахиц гарсан байна. Гүйцэтгэлд тавих хяналт сайжирна. | МТИХ, Бүх хэлтэс | Албан хэрэгцээнд дотоод сүлжээний www.able.mn e-Office системийн хэрэглээг сайжруулан ажиллаж, албан хаагч бүрийн өдөр тутмын ажлын үр дүнг удирдлагын зүгээс хянан, холбогдох албаны мэдээллийг байгууллагын дотор уг сүлжээгээр дамжуулан мэдээлж хэвшсэн. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар болон газрын 7 хоногийн шуурхай хурлаас өгсөн үүрэг чиглэл, 7 хоногийн хийсэн ажлын тайлан, цаг үеийн холбогдолтой зарлал, мэдээллийг дотоод сүлжээний "Олон нийт" хэсэгт байршуулан дотоод мэдээллийн ил тод байдал болон хэлтэс, албан хаагчдын ажлын уялдаа холбоог ханган ажиллаж байна. Дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагаанд гарсан асуудлуудыг тухай бүрд нь шийдвэрлэн ажиллаж байна. (Б-100%) |
| **Арга хэмжээ 12.6.66.** Нэг цэгийн үйлчилгээний заалны мэдээллийн цахим самбар, байгууллагын хяналтын камерын хэвийн жигд ажиллагааг хангах | - Иргэдэд цахим мэдээллийн самбараар худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх,<br>- Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, камерын системийг ажиллуулах,<br>- Жилдээ. | Иргэдэд худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээллийг шуурхай хүргэсэн байна. Байгууллагын дотоод хяналт сайжирсан байна. | МТИХ, ЗУХ | Байгууллагын "Нэг цэгийн үйлчилгээний төв"-өөр 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт 10370 (давхардсан тоогоор) иргэн, аж ахуйн нэгжид үйлчилж, мэдээлэл, лавлагаа, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэв.<br>Үйлчилгээг төрлөөр нь ангилан тоон үзүүлэлтээр дурдвал:<br>1. Утсаар өгсөн зөвлөгөө – 3364,<br>2. Биечилж өгсөн зөвлөгөө - 2403,<br>3. Цахим системийн бүртгэл (PKI) код олгосон - 1726,<br>4. Ирсэн бичиг хүлээн авсан - 672,<br>5. Албан бичиг хүргэсэн - 553,<br>6. Мэдэгдэл, тодруулга хүргэсэн - 235,<br>7. Цахим тендер илгээсэн, тохиргоо хийсэн - 369,<br>8. Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | гэрчилгээ олгосон - 670,<br>9. Цахим өргөдөл баталгаажуулсан - 378.<br><br>2016 онд орон нутгийн болон дүүргүүдийн ХААА-аас зарлаж буй цахим тендерийн тоо өмнөх жилээс нэмэгдсэнтэй холбоотойгоор цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөгөө, лавлагааны тоо үйлчилгээний бусад төрлөөс өндөр үзүүлэлттэй хэвээр байна.<br>Аж ахуйн нэгжийн төлөөллийг цахим системийн сургалтад бүртгэж, хувийн нууцлалын код (PKI) үүсгэж тохиргоо хийх, материал илгээх, хамгаалалтын программ хэрхэн татаж суулгах, нийлүүлэгчийн бүртгэлд бүртгүүлэх заавар, банкны баталгааг хэрхэн цахимаар илгээх, тендерт оролцох төлбөрийг хэрхэн төлөх заавар зэрэг бүх талын тусламж үйлчилгээг утсаар асуусан болон биеэр ирсэн үйлчлүүлэгчдэд үзүүлж, дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажилласнаар аж ахуй нэгж, байгууллагуудын холбогдох албан хаагчдын цахим тендерийн талаарх мэдлэг сайжирч, тендерийн материалыг илгээхтэй холбоотой хүндрэл гарахгүй болсон.<br><br>“Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн утсанд гаднаас хандсан дуудлага бүрийн бүртгэлийн түүхийг хөтөлж байна. Нэг цэгийн үйлчилгээний танхим, угтах хэсгийн цахим мэдээллийн самбар, камерын хэвийн үйл ажиллагааг хангаж, цахим самбарт тухай бүр мэдээллийг шинэчлэн мэдээлж хэвшив. (Б-100%) |
| **ДҮН (66 арга хэмжээ)** | | | | |

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА

(Газрын даргын ҮДГ буюу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт ажлаар)

Төсвийн шууд захирагчийн Үр дүнгийн гэрээ буюу байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг оны эхний хагас жилийн байдлаар гарган дүгнэв. Хэрэгжилтийн явцын дүнгээс дүгнэхэд, 2016 онд төлөвлөсөн нийт 66 зорилт (арга хэмжээ)-ын хэрэгжилтийн явц дунджаар **88,9 хувийн** гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилтийн дүнг тооцохдоо Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан аргачлалыг баримтлан дүгнэв.

Хэрэгжилтийн явцын дүн

| Д/д | Хэрэгжилтийн явц | Заалтын тоо |
|---|---|---|
| 1 | Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ | **66** |
| 2 | Бүрэн хэрэгжиж биелсэн – (Б.) | 25 |
| 3 | Хэрэгжих шатандаа – (ХШ.) | 36 |
| | Үүнээс: 90% | 26 |
| | 70% | 4 |
| | 50% | 6 |
| | 30% | - |
| | 10% | - |
| 4 | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй хүлээгдэж байгаа - (ХБ.) | 5 |
| 5 | Тасарсан – (Т.) | - |
| **6** | **Хэрэгжилтийн хувь** | **88,9** |

ТАНИЛЦСАН:
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ,
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ОТГОНБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ЖАРГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

2016 оны 06 сарын 28 өдөр